

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:**

1-8

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

9-54

-
- | | |
|--|--------------|
| 1.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 11-37 |
| 2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 37-48 |
| 3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн томилгооны тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/ | 48-54 |

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
12 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 50 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баярмаа, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Г.Дамдинням,
Л.Соронзонболд, С.Эрдэнэболд;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, М.Нарантуяа-Нара;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар, У.Отгонбаяр, Б.Тулга.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх эсэх асуудлыг нэгдүгээр асуудал болгон хэлэлцэх горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул нэгдүгээр асуудал болгон хэлэлцэхээр тогтов.

Нэг.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гүйцэтгэгч О.Оюунзул, Улсын ерөнхий прокурорын газрын Бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах прокурор З.Сансарзолбоо, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн П.Золзаяа, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Б.Мандалбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Банкны төлбөр барагдуулах газрын дарга Б.Дашдаваа, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын ДНХ-ийн лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор О.Амарсанаа Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор О.Отгонтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Х.Баасанжаргал, О.Алтангэрэл, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн П.Золзаяа, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын ДНХ-ийн лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 3

Бүгд: 15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 3

Бүгд: 15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Мөнгөнтуул, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, мөн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Г.Ганбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн П.Золзаяа, Г.Даваадорж, мөн зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Улсын ерөнхий прокурорын газрын Бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах прокурор З.Сансарзолбоо, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга К.Нямдаваа, Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны Зөрчлийн хэрэг бүртгэл, мэргэжил, арга зүйн хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч П.Алтанзул, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Н.Норовсамбуу, Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор О.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр референт Б.Баярсайхан нар байлцав.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн П.Золзаяа, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, мөн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 8.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн томилгооны тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг уг асуудлыг хойшлуулах горимын санал гаргаж, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Алтангэрэл, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 40 минут үргэлжилж, 27 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 50 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирц Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Баярмагнайн Баярбаатар, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц 51.9 хувьтайгаар бүрдсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байж байгаа.

1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл.

2.Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл, Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал байж байгаа. Энэ өмнөх хоёр хууль хоёулаа хэлэлцэх эсэх асуудал.

Гурав дахь нь Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгье.

Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Нэгэнт Даргын дэргэдэх зөвлөл дээр бас энэ хэлэлцэх асуудлын дэс дарааллыг уг нь тогтоож өгсөн юм байна. Уг нь жоохон логиктой баймаар байна.

Нэгдүгээрт, материаллаг хуулиа ярьдаг. Гэр бүлийн хуулийн 99 оны Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга буюу энэ материаллаг зохицуулалт ямар өөрчлөлт орж байгаа юм бэ гэдгийг ярьчихад дараа нь энэ материаллаг

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зохицуулалтаас үүдэн гарах процессоо ярих ёстой байхгүй юу. Одоо болохоор ингээд процессоосоо эхлэх гэж байна. Тэгээд угаасаа Гэр бүлийн хуультайгаа уялдаж явна. Ингээд логикгүй ингээд хэлэлцүүлэг ийм сонин дэс дараатай л болох гээд байна. Би одоо энэ горимын санал гаргаад ч энэ дотор хүрэхгүй л байна л даа.

Тэгэхээр яамаар байгаа юм болдог бол уг нь материаллаг хуулиасаа буюу Гэр бүлийн хуулиасаа асуудлаа яриад тэгээд эндээс үүдэн гарах маргаан дээр шүүх хэрхэн оролцох вэ гэдгийг ингээд дэс дарааллын хувьд яривал уг нь байна. Дарга бас таны бүрэн эрхийн хүрээнд бололцоо байдаг бол заавал санал хураахгүйгээр дэс дарааллаа ингээд яриад явчхаж болж байгаа гэдэг зүйлийг бас хэлье. Горим гаргаад унахаас ялгаагүй энд чинь ингээд 5-хан хүн сууж байхад горим гаргаад нэмэр алга. Ийм л байдалтай хууль хэлэлцэж байна даа. Энийг анхаарч өгнө үү?

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн саяынхаа саналыг горимын санал болгоод томъёолчих. Би үүний өмнө нэг зүйл хэлчихье. Энэ яг Байнгын хорооноос Даргын дэргэдэх зөвлөл рүү энэ зөв дэс дараагаар өөрөөр хэлбэл эхлээд Гэр бүл, хүүхдийн тухай хуулиа оруулаад дараа нь процессын хуулиа оруулъя гэсэн ийм дэс дараатай явуулсан байна. Даргын дэргэдэх зөвлөл дээр яагаад ингэж өөрчилсөн гэхлээр засгаас өргөн барихдаа ийм дэс дараатай барьчихсан. Тэрүүгээр нь л өөрчилчихсөн байгаа юм байна. Одоо горимын саналаар Сайнзориг гишүүн горимынхоо саналыг гаргачих.

П.Сайнзориг: Баярлалаа дарга. Хэдүүлээ энэ 99 он нийгмийн суурь харилцааг зохицуулж байгаа хувийн эрх зүйн суурь байгаа. Дээрээс нь нийтийн эрх зүйн ч суурь байгаа. Хамгийн эмзэг энэ асуудал учраас материаллаг хуулиасаа бас ойлголтуудыг нь аваад явъя гэж бодож байгаа учраас 1 дүгээрт, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлээд араас нь Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тэгээд бусад асуудлаа хэлэлцээд явъя гэсэн ийм дэс дарааллаар горим гаргаж байна. Та бас саналыг хураалгаж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын та томъёолсон саналыг дэмжье гэж санал хураалт явуулъя. Манайхан санал хураалтдаа бэлдээрэй. Сайнзориг гишүүний горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57 хувиар санал дэмжигдлээ. Ийм учраас би хэлэлцэх асуудлын дэс дарааг шинээр танилцуулъя.

Нэгдүгээр асуудал, Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл, Засгийн газраас 25 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал.

Хоёрдугаар асуудал, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл. Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гуравдугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлаа баталлаа. Хэлэлцэх асуудалдаа ингээд орно.

Нэгдүгээр асуудал. Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт танилцуулна. Бямбацогт гишүүний микрофоныг өгье сайдын.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл зэрэг бодлогын бичиг баримтад тусгасан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Хувийн эрх зүйн асуудлуудыг зохицуулж байгаа суурь хуулийн нэг нь 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль боловч тус хууль нь гэр бүл, хүүхдийн эрхийг хангахад хангалтгүй. Цаашлаад хувьсан өөрчлөгдөж буй гэр бүлийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүйгээс практикт гэр бүлийн харилцааны олон асуудал гарахад хүүхэд, гэр бүлийн гишүүдийн эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байна.

Мөн гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалт, гэрлэлтийн гэрээ, хамтын амьдралыг гэрлэлттэй адилтгах нөхцөл, хүйс солиулах нь гэрлэлтэд ямар үр дагавар үүсгэх, тээгч эхээр хүүхэд тээлгэх, зохиомлоор үр суулгах нь гэр бүл өв залгамжлалын эрх зүйгээр хэрхэн зохицуулах гэх мэт шинэ тулгамдаж буй асуудлуудыг уг хууль бүрэн зохицуулж чадахгүй болно.

Иймээс хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусгалаа.

1.Монгол Улсад гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ жил ирэх тутам нэмэгдэж байгаа хэдий ч гэрлэлт цуцлахдаа хүүхдийн асуудлыг хамтад нь шийдвэрлэхгүй байх тохиолдол цөөнгүй байна. Иймд гэрлэлт цуцлалтаас болж хүүхэд хохирохгүй байх, хүүхдийн тэтгэлэг, хүүхдийн асрамж, тусдаа амьдрах, эцэг эсхүл эхийн хүүхэдтэйгээ уулзах асуудлыг гэрлэлт цуцлалтай хамтад нь заавал шийдвэрлэхээр тусгалаа.

2.Хүүхдийн тэтгэлгийн хэмжээг амьжиргааны доод түвшний хэмжээгээр бус тэтгэлэг төлөгчийн хөрөнгө орлого, тэтгэлэг, авагчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тогтоох. Хүүхдийн тэтгэлгийг сургуульд сурч байгаа 18-21 насны болон

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

асаргаа, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд наснаас үл хамааран, хамааран олгохоор тусгалаа.

3.Гэрлэлт дуусгавар болсноос тусдаа амьдрах болсон эцэг эсхүл эх хүүхэдтэйгээ уулзах, уулзуулах үүргийг хуульчилж, хүүхэдтэйгээ уулзахгүй эсхүл хүүхэдтэй нь уулзуулахгүй бол Зөрчлийн тухай хуулиар албадан биелүүлж, шийтгэл оногдуулахаар тусгаж эцэг, эх, хүүхдийн өмнө эцэг, эх байх хүүхдийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг нэмэгдүүлэх хөшүүргийг бий болголоо.

4.Гэрлэлтийн гэрээ байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, гэрлэлтийн гэрээ байгуулсан бол гэрлэлт цуцлахад гэрээний дагуу дундын эд хөрөнгийг хуваах нөхцөлийг бүрдүүллээ.

5.Таваас доошгүй жил хамтран амьдарч эд хөрөнгө бий болгосон хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусгавар болоход гэрлэгчид дундын эд хөрөнгөө хуваадагтай адилтган үзэхээр тусгалаа.

6.Цус ойртолтоос сэргийлж гэрлэлт бүртгүүлэхээс өмнө садан төрлийн холбоотой эсэхээ шалгуулж болохоор тусгалаа.

7.Хүүхдийг үрчлүүлэх асуудлыг Засаг дарга шийддэг бус шүүх шийдвэрлэх байдлаар үрчлэлтийн асуудлыг олон улсын жишигт нийцүүллээ.

8.Хүүхэд асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоохдоо тэргүүн ээлжид гэр бүлийн орчинд өсөн торних нөхцөлийг хангаж, асралт гэр бүлийн талаар тусгасан.

9.Гэр бүлээс гадуурх харилцааны улмаас гэрлэлт цуцалбал буруутай гэрлэгчийн сэтгэл санааны хохирлоо нөгөө тал нэхэмжлэх, мөн энэхүү нөхцөл байдлыг дундын эд хөрөнгөө хуваахад харгалзан үзэхээр тусгалаа.

Түүнчлэн гэр бүлээс гадуурх харилцааны улмаас гэрлэлт цуцалсан бол хүүхэд нь буруутай эцэг эсхүл эхээ заавал тэжээн тэтгэх үүрэггүй байхаар тусгалаа.

10.Хүйсийн өөрчлөлтийн улмаас гэрлэлт дуусгавар болох, тээгч эхээр хүүхэд хийлгэхэд гэрээ байгуулсан гэрлэгчид хүүхдийн эцэг, эх байхаар, мөн өөр хүний бэлгийн эсийг ашиглан хүүхэдтэй болбол өөр хүний бэлгийн эс ашигласан гэрлэгчид хүүхдийн эцэг, эх байхаар тусгалаа.

Хуулийн төслийг дагалдуулан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг 10 хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Бямбацогт сайдад баярлалаа.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Энэ хуулийн төслийг хэлэлцүүлж байгаатай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Золзаяа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Мандалбаяр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүгч, Оюунтуяа СБД-ийн Иргэний хэргийн анхан шатын шүүгч, Жавхлан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Оюунзул Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сансарзолбоо Улсын ерөнхий прокурорын Бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах прокурор, Амарсанаа Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн доктор, дэд профессор, Цогтбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч, Тэнүүн Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын ДНХ-лабораторийн эрхлэгч, цагдаагийн хошууч ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг энэ хуралдаанд оролцож байна.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Бүгдэд нь бага үдийн мэнд хүргэе. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байна. Маш том асуудал гэж хувьдаа бодож байна. Энэ гэр бүлийн асуудал, хуулийн нэмэлт, өөрчлөлт шинэчилсэн найруулга орж ирэх хэрэгцээ, шаардлагууд зайлшгүй нийгмийн хөгжлийн нийгмийн харилцааг дагаж ингэж орж ирэх үндэслэл шаардлага нь бага байх гэж бодож байна. Одоо мөрдөгдөж байгаа хууль нь бас нийгмийн харилцаа тэр болгон зохицуулж чадахгүй олон талын нийгмийн гэр бүлийн харилцаанууд үүсэж байгаа учраас хууль бас хоцрогдож хуулиар зохицуулалтгүй олон харилцаанууд бий болж байгаа учраас энэ хууль шинэчилсэн найруулга хийх үндэслэл, шаардлага зайлшгүй бий болсон.

Гэр бүл нийгмийн анхдагч нэгж гэрлэгчид гэр бүл болсноор зайлшгүй эцэг, эх байх нийгэмд асар том үүрэг, хариуцлага үүрч бий болж байна. Ер нь энэ гэр бүл болох өнөөдөр Ииргэний бүртгэл дээр улсын бүртгэгч нар л гэрлэлтийг бүртгэж байгаа байх. Гэрлэгч нар хэн байхаас үл хамаараад тэр тусмаа анх удаа гэр бүл болж байгаа залуу хосуудад энэ гэр бүлийн үнэ цэн, гэрлэлтийн эцэг, эх байхын ач тус, үүрэг, хариуцлагын талаар ер нь 10 жилийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрүүдэд одоо ер нь яг ямар хичээл, сургалт орж байгаа юм бэ? Сургалтын хөтөлбөрт ямар энэ чиглэлээр мэдээ, мэдээллүүдийг өгдөг юм бэ? Энэ Улсын бүртгэл, Иргэний бүртгэлийн бүртгэгч нар тэр талаар огт сургалт хийхгүй байгаа гэж би ойлгож байгаа юм. Зүгээр л холбогдох материал юмнуудыг нь бүрдүүлснийг нь бүрдүүлбэрийг нь хангаад л ингээд л гэрлэлтийг бүртгэж байгаа юм. Ингээд энэнээс үүдэлтэйгээр үр дагавар нь бас гэр бүлийн үнэ цэн, утга учир, үүрэг, хариуцлагыг дутуу ухамсарласнаас болж бас гэр бүлийн салалтад бас тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа л гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр бат бөх гэр бүл байх асуудлаар энэ сургалт, мэдээллийн, нөлөөллийн асуудлын чиглэлээр одоо мөрдөгдөж байгаа хуульд ямар байна? Энэ шинээр орж ирж байгаа шинэчилсэн найруулгад ер нь энэ чиглэлээр миний

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мэдэхийн энэ Гэр бүл ёслолын ордонд бас их том сэтгэл зүйч нар ийм сургалт хийдэг юм байна лээ хүсвэл. Өөрсдөө хүсэлт гаргавал. Хүсэлт гаргахгүй бол энэ чиглэлийн сургалт юмны сэтгэл зүйн зөвлөгөө өгөх асуудал бол ер нь бараг байхгүйтэй адилхан гэж хэлж болохоор байна. Аймаг, дүүргүүдийн гэр бүлийн улсын бүртгэгч нар дээр. Тэгээд энэ утга учрыг нь, ач холбогдлыг нь ойлгуулахгүйгээр цаашдаа энэ гэр бүл бат бөх байх асуудал ер нь орхигдоод байгаа юм биш үү? Энэ тал дээр хуулийн төсөлд яаж тусгаж оруулж ирж байгаа?

Д.Цогтбаатар: Тэгье, тэгвэл Бямбацогт гишүүний, сайдын микрофоныг өгөөд дараа нь 4 дүгээр микрофон өгөх үү? Тэгье .

С.Бямбацогт: Баярлалаа. Тэгээд Гэр бүлийн тухай хуулийг 1999 онд баталсан. Түүнээс хойш бас энэ нийгмийн хөгжил, цаг үеийн бас өөрчлөлт, хөгжил дэвшилтэй холбоотойгоор энэ хуулийг бас шинэчилж найруулах гэж бас олон удаа үе үеийн Засгийн газраас бас өргөн барьж хэлэлцүүлэх гэж бас оролдож байсан. Тэгээд энэ асуудал нь хэлэлцэгдэж батлагдаж чадахгүй байсаар өнөөдөр ингээд Засгийн газраас Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээр оруулж ирж байгаа.

Аливаа төр улсын үндэс нь ерөөсөө л өрх гэр, гэр бүл байдаг. Тийм болохоор гэр бүл маань хэрхэн бат бэх харилцаатай, гэр бүл улс орны хөгжлийн үндэс болсон үр хүүхдээ хэрхэн, яаж өсгөж хүмүүжүүлэх вэ гэдэг энэ харилцааг илүү бас цаг үетэйгээ нийцүүлж нарийвчилж зохицуулах ийм шаардлага үүссэн. Энэ ч гэсэн Монгол Улсаас Үндсэн хуульд улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын, амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон, насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална гэж заасан Үндсэн хуулийн заалт байдаг. Энэ заалтаа бас илүү хэрэгжүүлэх, мөн бас төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасан. Одоо хүүхдийн эрхтэй холбоотой.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтад хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих, идэвхтэй бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ гэж заасан. Иймэрхүү бас томоохон бодлогын бичиг баримтууд дээр тулгуурлаж зайлшгүй энэ хуулийг бас шинэчилж, найруулж өөрчлөх ийм шаардлагатай гэж үзэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, мөн 2024-2028 онд Монгол Улсын хууль тогтоомжийг бас боловсронгуй болгох үндсэн чиглэлд ч гэсэн энэ талаар бас тусгасан байгаа. Тийм болохоор бас нийгмийн суурь харилцааг зохицуулсан энэ их томоохон хуулийг бас Засгийн газар оруулж ирсэн. Улсын Их Хурлын гишүүд маань бас маш хариуцлагатай, анхааралтай, хүндэтгэлтэй бас хандаад энэ хууль маань бас батлагдах байх гэж бодож байгаа. Энэ тал дээр манай ажлын хэсгээс сая Сандаг-Очир гишүүний асуусан асуултууд дээр бас нэмэлтээр тодруулаад бас хариулчихъя. Их суурь чухал хууль учраас та бүхэндээ баярлалаа гэдгийг бас хэлье хэлэлцүүлж байгаад.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье.

Н.Мягмар: Сандаг-Очир гишүүний асуултад тодруулж хариулъя Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Энэ гэр бүлийн үнэ

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

цэн, гэр бүл болохын утга учир, энэ гэр бүлийн гишүүдийн хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой энэ боловсролын байгууллагын хүрээнд ямар асуудлуудыг шийдвэрлэж байна вэ гэдэг энэ асуудал байна. Боловсролын багц хууль батлагдаж энэ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Энэ Боловсролын ерөнхий хуулиар бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, сургалтын байгууллагын өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хэрэгжүүлнэ гэдэг энэ зохицуулалт дотор 14.2 дээр хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийн талаар тусгаж заавал хэрэгжүүлнэ гэсэн юм.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд өгье 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Боловсролын ерөнхий хуулийн энэ зохицуулалт байгаа. Тийм учраас энэ боловсролын яам энэ чиглэлээр сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд энийг тусгаж зохицуулж байгаа байх гэж ингэж бодож байна.

Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд энэ хуулийн төслийн 5.4 дээр гэрлэхийг хүсэгчдийн хэн нь анх удаа гэр бүл болж байгаа гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдана. Энэнтэй холбоотой журмыг нь гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсэн энэ зохицуулалт орж ирж байгаа. Тэгэхлээр энэ сургалтын гол зорилго бол анх удаа гэр бүл болж байгаа гэрлэгчид маань Сандаг-Очир гишүүний хэлдгээр гэр бүлийн үнэ цэн, гэр бүл, гэрлэгчид ямар үүрэг хүлээдэг вэ асран тэжээх, тэжээн тэтгэхтэй холбоотой ямар үүрэг, хариуцлага хүлээдэг вэ гэдэг энэ гэр бүлийн үнэ цэний асуудал бол зөвхөн гэрлэгч хоёрын сайн дурын хайр сэтгэлийн үндсэн дээр бий болоод хэсэг хугацааны дараа ингээд хоёр тийшээ болчихдог асуудал бас биш юм гэдэг энэ агуулгыг илэрхийлэх ийм сургалтын хөтөлбөрийн агуулга тусаж байгаа.

Мөн нөгөө талаасаа гэрлэгчдийн гэр бүлийн харилцаанд хүлээх үүрэг дээр гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг хүүхдэдээ өвлүүлэх, оюун санааны дархлааг бэхжүүлэх гэсэн ийм үүргүүдийг энэ шинэчилсэн найруулгын төслүүд дээр оруулж ярьсан байгаа.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн хангалттай юу? Тэгвэл Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Хуулийн төсөл ер нь эерэг тал нь зөндөө байна. Ялангуяа хүний эрхийг хамгаалсан, хүүхдийн эрхийг нэгдүгээрт тавьсан, гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлсэн гэсэн олон зүйл, заалтууд байна. Энэ дээр дэмжиж байгаа байр суурьтай байна.

Гэхдээ нөгөө талд бас Засгийн газраас орж ирж байгаа зүйл учраас хэлсэн ярьсан нь зөрөөд байна. Засгийн газрын саяхан бид нар таван жилийн хөтөлбөр баталсан. Тэгээд аль болохоор л иргэддээ төвөг учруулахгүй, төрийн үйл хэргийг аль болохоор энэ аж ахуйн нэгж, иргэдийн дарамтгүй байх тал дээр нь төр аль болохоор энэ үйл ажиллагаанд бага оролцдог байх тал дээр байна гээд л Ерөнхий сайд маань удаа дараа мэдэгдсэн.

Тэгэхээр би энэнтэй зөрчилдөж байгаа хэд хэдэн зүйл, заалтууд байна. Жишээгээр асрамжийн түр байршуулалт гээд сэдэв байна. Энэ дээр шүүхээс бас л

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шийдвэр гаргаад л тэгээд л асрамжид хүүхдүүдийг түр байршуулах энэ асуудал орж ирж байгаа юм. Энэ бол маш олон маргаан дагуулах шүүх бас хэдэн шатаар явж эцэслэх вэ, тэр хугацаанд хүүхдүүд ямар нөхцөлд байх вэ, ар гэрийн ингээд тодорхойгүй заалтууд их байна. Тэгэхээр шүүхийн ачаалал нэмэгдэнэ. Асрамжийн үйл ажиллагаа төсөв, зардал гээд энэ нь суугдсан юм уу?

Дараагийнх нь хүүхдийн саналыг авах шинжээч томилох гээд л. Хэчнээн хэмжээний шинжээч Монгол Улсад бэлэн байгаа юм, боловсон хүчний бодлого нь байгаа юм уу, хувийн хэвслээс явах юм уу, дахиад түр баахан шинжээч томилох юм уу гэдэг асуудал байна.

Дараагийн дугаарт гэрлэлт бүртгүүлэхэд эрүүл мэндийн заавал шинжилгээ гээд ороод ирсэн. Энэ ямар журмаар явж байгаа юм, хэдий хэмжээний ачаалал үүсэх юм? Ялангуяа эдийн засагт төрөөс байх юм уу, хувиас байх юм уу төр огтхон хариуцах юм уу үгүй юү гэдэг дээрээ нийтэд ил болгох хэрэгтэй. Гэр бүл бүртгэхээс өмнө заавал сургалтад хамрагдана гэж байгаа юм. Энийг нь дахиад төр тендер шалгаруулах юм уу, төрөөс явах юм уу? Хувийнхан өөрсдөө гэр бүл болох гэж байгаа нөхдүүд хувийн байгууллагаар мөнгөө төлөөд явах юм уу? Энийгээ яг эдийн засгийн хувьд нийгэмд бас яг тодорхой дүнгээр, тоогоор, мөнгөн дүнгээр хариулт авмаар байна.

Тэгээд ийм сонин зүйл заалт хамтран амьдрагчдыг хуульчилсан байгаа юм. Тэгэхээр энэнээс үүдээд эдийн болон хөрөнгийн маргаан.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон Мягмар дарга эхлээд хариулъя. Тэгээд та өөрөө хэлнэ биз хэнээр хариулуулах вэ? 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Гэр бүл цуцлах асуудлыг шүүхийн шатанд хэлэлцэх тохиолдолд шийдвэр гарахаас өмнө бас асрамжийн асуудлыг шүүх урьдчилсан авах арга хэмжээний төрлүүдэд таны саяын ярьж байгаа асрамжид түр байлгах асуудал орж ирж байгаа юм. Яг цэвэр хүүхдийн асрамж, тэтгэлэгтэй холбоотой гэдэг юм уу асран хамгаалагч, харгалзан дэмжлэг тогтоохтой холбоотой асуудал өмнө нь явж ирсэн энэ зохицуулалт үндсэндээ байгаа. Гэхдээ одоо энэний эрэмбийг нь оруулж өгч байгаа юм.

Тухайлбал, хүүхдийг шууд асрамжийн газарт шүүгч шилжүүлэх ийм шийдвэр гаргадаг бол хүүхэд гэр бүлийн орчинд өсөх гэдэг энэ агуулгыг хамгаалах үүднээсээ мэдээж төрөл садны хүнд нь эхний ээлжид асран тэтгэлгийг нь тогтоох, 2 дугаар шатад асралт гэр бүл буюу олон улсад хэрэглэдэг “foster family” гэдэг энэ гэр бүлийн орчинд өсөх ийм боломжийг шүүгч эрэмбийн хувьд авна гэсэн энэ агуулгаар асрамж, харгалзан дэмжлэгийн асуудал зарчим нь ингэж орж ирж байгаа.

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн асуудал бол энэ гэр бүлийн хэрэг, хүүхдийн хэрэг шүүхэд дагнасан ийм шүүх байгуулсантай холбоотойгоор хэрэг хянан шийдвэрлэх ийм процессын хууль дээр энэ маань орж ирж байгаа. Нөхцөл байдлын шинжээч маань гэр бүл цуцлахтай холбоотой асуудал дээр гэр бүлийн нөхцөл байдлыг нь судлаад энэ шинжээч маань шүүхийн бүтцэд ажиллахаар ингэж оруулж ирж байгаа. Ингэснээрээ энэ гэр бүл цуцлах асуудлыг хүүхдийн эрх ашгийг тэргүүн зэрэгт хамгаална гэдэг энэ зарчмын хүрээнд шийдвэрлэх боломжийг нь шүүгчид тайлан гаргаж өгөх замаар шүүгчийн шийдвэрээ

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үндэслэлтэй, бодитой, хүүхдийн эрх ашигт нийцсэн байдлаар гаргахад нь туслах энэ олон улсын жишгийн дагуу энэ гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн зохицуулалт орж ирж байгаа.

Хүний нөөцийн асуудлуудыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон гэр бүл, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн яамдын зүгээс энэ хүний нөөцийн сургалт, нийгмийн ажилтнуудын энэ сургалтаараа дамжуулаад бэлтгэнэ гэдэг ийм зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөж байгаа.

Хэд хэдэн эрүүл мэндийн шинжилгээний асуудлууд байж байгаа. Саяын дурддаг ДНХ-ийн шинжилгээ болон сэтгэцийн эрүүл мэндэд эрүүл байх энэ шинжилгээнүүдээ иргэд маань өөрсдөө зардлаа гаргаж энийгээ хийх юм. Ялангуяа тэр удам дамжлага сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой гэдэг юм уу, халдварт өвчтэй ДОХ-ын энэ тэр гэдэг энэ шинжилгээнүүдээ одоо хүртэл зохицуулалтаараа хийгээд явдаг. Иргэд ч энийгээ, шинжилгээгээ хариуцаад явдаг. Шинээр тэр ДНХ-ийн буюу садан төрлийн холбоотой байгаа эсэхээ хүсвэл өөрсдөө хийлгэх ийм зохицуулалтыг ор.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Одоо нэг л удаа нэмэх юм. Тэгээд дараа нь тодруулна. Бямбацогт гишүүн сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Асран хамгаалахтай холбоотой асуудал хуучин Гэр бүлийн тухай хуульд байсан. Одоо бол илүү бас иргэд рүүгээ ойртуулж, асран хамгаалахдаа та бол сая шууд асрамжийн газарт аваачих гээд байх шиг байна гэж ойлгож байх шиг байна. Үгүй эхлээд гэр бүлийн орчинд аав дээр нь юм уу, ээж дээр нь, ах, дүү нар дээр нь, төрөл садан дээр нь, бүүр болохгүй бол асрамжийн газар руу гэсэн үе шаттайгаар. Ингэхдээ баг хорооны Засаг дарга, баг хорооны нийгмийн ажилтан нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж байж энэ шийдвэрийг гаргаж үе шаттай хийхээр ингэж бас хуульд оруулсан юм байна лээ.

Хамтран амьдрагчтай холбоотой асуудал Гэр бүлийн тухай хуульд байхгүй. Яах аргагүй амьдрал баян амьдрал дээр хамтарч амьдрах нэлээн нас гарчихсан хижээл болсон хойноо аргагүй амьдралын эрхээр бас аяга цайгаа хувааж уух тэр үедээ гэрлээд байх шаардлагагүй. Гэтэл түүнээсээ болоод бас хамтарч амьдарч байгаад асуудал үүсвэл бас энэ харилцааг хэрхэн яаж зохицуулах вэ? Зохицуулалт байхгүй. Иймэрхүү бас амьдрал дээрээс л.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Тодруулъя Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: За за. 2 тодруулна тээ дэгээрээ? Би эхний ээлжид эдийн засгийн хувьд ямар ачаалал төсөв дээр ирж байгаа юм бэ? Иргэд дээр жилийн дундаж дүнгээрээ нийт одоо эзлэхүүн нь нарийн төсөөлж байгаагаар хэчнээн хэмжээний тэр жилд хэдэн хүн гэрлэдэг юм, түүнээс улбаалаад заавал шинжилгээ өгөх асуудал хуульчилчихаар заавал ч үгүй иргэд дээр өөрсдөө төлөх юм байна л даа. Тэгэхдээ л энэ чинь бизнес байхгүй юу. Тэгээд сургалт явах нь байна бас бизнес. Тэгээд одоо бол ийм юм байгаа шүү дээ халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг яам гэхэд чинь халамжийн сургалт эрхэлдэг тусдаа ийм бизнесийн бүүр кластер үүсчхээд байгаа шүү дээ. Энийг яг тоон байдлаар надад хэлээдхээч тэгээд тодруулъя.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Н.Мягмар: Энэ шинжилгээ хийхтэй холбоотой зардлын асуудал энэ тэр дээр одоо байгаагаар жишээ нь эцэг тогтоох шинжилгээ гэдэг ийм ДНХ-ийн шинжилгээ бол иргэн улсын тэмдэгтийн хураамжийнхаа дагуу тэмдэгтийн хураамж төлж 180 мянган төгрөгөөр жишээ нь хийлгээд ингээд явж байгаа.

Таны саяын дурдаж байгаа шинээр орж ирж байгаа тэр гэр бүлийн сургалт энэ тэртэй холбоотой төлбөртэй байх уу, эсвэл ямар хэмжээний зардал үүсэх вэ гэдэг энэ асуудал дээр гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын асуудал эрхэлсэн сайд маань энэ журмаа батлахаар ингэж зохицуулж өгч байгаа. Гэр бүлийн яам энэ тэртэй бидний ажлын хэсгийн хүр хүрээндээ ярьж байгаагаар энийг аль болох иргэдэд чирэгдэлгүй хэлбэрээр зохион байгуулах тал дээр ярьж байгаа юм. Тухайлбал юу гэдэг юм, энэ гэр бүлийн боловсрол олгохтой холбоотой сургалтыг цахим модуль хэлбэртэй сургалтын хөтөлбөр боловсруулаад энийг цахимаар оролцоод тодорхой хэмжээний мэдээллийг нь авсан гэсний үндсэн дээр ард нь тийм олсон мэдлэгээ бат.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сая энэ Пүрэвдаваа гишүүний асууж байгаа юм аягүй тодорхой юм асуучихлаа шүү дээ. Аягүй чухал юм асууж байгаа юм. Төсөв дээр ямар дарамт ирэх вэ? Тийм тооцоолол та нар хийсэн үү? Одоо энэ шинэ Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн шинэ агуулга чинь аливаа хууль оруулж ирэхдээ төсөв дээр бүр яг маш тодорхой зааж авах ёстой гэж хэлчхээд байгаа шүү дээ.

4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Яг энэ сургалт саяын зүйлүүдтэй холбоотой шинжилгээний юунууд дээр төсөв дээр зардал орж ирэхгүй. Яагаад гэхлээр энэ зардлаа иргэд өөрсдөө хариуцах юм. Сайн дурын үндсэн дээр жишээ нь ДНХ-ийн шинжилгээ 2028 оноос мөрдөж эхлэх юм. Тэгэхлээр энэ холбогдолтой асуудал дээр төсөв рүү зардал гэж орж ирэхгүй. Харин төсөв рүү ямар асуудлууд орж ирэх вэ гэхлээр энэ дагнасан шүүх байгуулагдсантай холбоотойгоор энэ шүүхийн бүтцэд нөхцөл байдлын шинжээч ажиллахтай холбоотойгоор шүүхийн орон тоон дээр энэ орон тооны цалин хөлс, урсгал зардлын асуудлууд орж ирнэ.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Хуралдааны тэмдэглэлд тусгуулж байгаад ийм асуулт асуумаар байна. Ялангуяа манай энэ ажлын хэсэг маань оруулж ирж байгаа төсөл дээрээ эдийн засгийн тооцооны хувьд жоохон сул ажилласан юм уу даа. Ялангуяа эргээд харах бас subject-ууд байна одоо. Ялангуяа миний харж байгаагаар энэ шүүхийн ачаалал хэдээр нэмэгдэж байгаа юм? Шүүхүүд тэлж байгаа юм. Дээрээс нь иргэд дээр яг үе шатын хувьд төрийн хүнд суртал нэмэгдэнэ.

Дээрээс нь манай Монгол Улсын онцлог байна. Маш том газар нутаг дээр тархай бутархай амьдарч байгаа. Хөдөө суманд энэ аягүй чирэгдэл үүсгэнэ. Хаана нь яаж хийдэг юм, аль тэр ингээд шүүхээр шийдвэр гардаг. Тэгэнгүүт хүүхдийг асрамжийн газар байлгана, эцэг, эх дээр нь байлгана. Яг юмаа тодорхой болгож байж орж ирэхгүй бол эргэлзээтэй, маргаантай нөхцөл байдал байна шүү. Энийг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон. Санал өгнө шүү дарга. Хариулах уу? 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Хууль тогтоомжийн хуулийнхаа дагуу хуулийн төслийн үр нөлөө болон зардлын тооцоо энэ тэрийг гаргасан. Тэгээд энэ зардлын тооцоо энэ тэр маань хуулийн төслийн бүрдүүлбэрт явж байгаа. Саяын дурдсанаар тэр шинжилгээ энэ тэртэй, сургалттай холбоотой зүйлүүд дээр улсын төсөвт ачаалал үүсэхгүй. Гагцхүү бүтэц, орон тоо нэмэгдэж байгаа дагнасан шүүх бий болж байгаатай холбоотойгоор энэ зардлын асуудлууд төсөв дээр нэмэгдэнэ гэдгийг л хэлж байгаа. Тэгээд энэ нарийвчилсан тоог танд тусгайлан зардлын тооцооноос салгаж гаргаж өгье.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Би уг нь олон асуулт байна. Тэгээд цагтаа амжих үүднээс хурдан асууя. Энэ хууль уг нь их олон жил боловсруулагдаад явж байгаа юм. Тэгээд үе үеийн сайдуудаар дамжаад л явж байгаа. 1 удаа өргөн бариад бас буцаж байсан ийм ч хууль байж байгаа. Ариунзаяа сайдын үед өргөн бариад бас тухайн үедээ Засгийн газар аваад Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийг төрөөс дэмжих тухай хууль гээд 2 салгахгүй бол болохгүй. Хувийн эрх зүй, нийтийн эрх зүйн асуудлыг хольж бас хуульчлах боломжгүй байна гэдэг үүднээс буцаж байсан юм. Тэгээд энэ дээр шинэ концепцын үед бас Европын улсуудад бий болсон хүйс солих байдаг юм уу, тээгч эх гэх зэрэг энэ харилцаануудаас үүсээд байгаа нөхцөлөөс энэ гэр бүлийн харилцаанд хэрхэн яаж нөлөөлөх вэ гээд.

Дээрээс нь энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой олон сөрөг үр дагаврууд байсан учраас энийг засъя гээд энэ уг нь явж байгаа ийм хууль байгаа юм. Яах вэ дэвшилттэй юмнууд нэлээн байгаа. Тэгэхдээ бас жоохон тодорхойгүй орхисон хэд хэдэн юм байна.

Би асуулт байна нэг байна. Ургийн овгийн асуудал байгаа. Хүүхэд төрөөд бас зайлшгүй эдлэх ёстой эрх байдаг бол нэртэй байх. Нэр авах эрх. Ээж аав, эцэг, эх нь нэр өгөх ийм эрхтэй байгаа. Энэ нэр өгөх эрх дээр ургийн овог байгаа. Монголчууд ургийн овгийг маш замбараагүй авсан. Энэ өөрөө эргээд зарим нь Боржигон ч гэдэг юм уу Боржигон гээд энэ овгийг бараг нийтээрээ авчихсан. Бичилтийн хувьд хэд хэдэн янзаараа байдаг.

Тэгэхээр энэ гэр бүлийн хуулийг уг нь шинэчилсэн найруулгын хувьд энэ ургийн овгийг дахин нэг баталгаажуулж авах асуудлыг уг нь хөндөж байсан юм. Энийг ингээд хаячхаад ороод ирсэн юм байна. Зарим нь тухайн үедээ мэдэхгүй сэтгэл хөөрлөөрөө Улсын бүртгэл дээр очоод бүртгэлээ шинэчлүүлэхдээ ямар овогтой гэхээр мэдээгүй, таниагүй, таниагүй учраас л овог хэлчихсэн.

Дээрээс нь сая бид нар бас Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатарын үед бид нар Польшоос Монголын хүн амын тооллогын материалуудыг хуулбарлаж авчирсан. Энэ зэргээр явах юм бол энэ баруун аймгаас бусдууд нь бас тооллогын материалыг бас архиваас үзэх бололцоо бүрдээд байгаа байхгүй юу. Энэ ургийн овгийг шинэчлэх асуудлыг 1 удаа энэ дагаж мөрдөх журмын хуулиар цэгцлээд үнэхээр энэ цус ойртолт байдаг юм уу, хүн ам зүйн бодлогын хувьд бас шийдэх асуудал байсан юм. Нэгдүгээрт энэ байгаа.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тээгч эхээрээ хэчнээн хүүхэд төрж байна? Энэнээс үүсэж байгаа эрх зүйн маргаанууд байна? Ер нь өв залгамжлал, бусад эрхүүд дээр ямар онцлог зохицуулалтууд оров? Гэрлэлтийн гэрээний асуудал байна. Яах вэ хайр сэтгэлийн асуудал учраас ийм зүйлийг ярихгүй гэдэг боловч амьдрал баян байна. Ер нь тэгээд сошиалаар гэр бүлийн маргаанаа шүүлгэж байгаа энэ үе дээр гэрлэлтийн гэрээний ач холбогдлыг бид нар таниулж өгөх ёстой байгаад байгаа. Тийм учраас энэ асуудал дээр одоо ямар зүйлүүд орж байгаа вэ? Асралт гэр бүлд тавигдах шаардлагын хувьд ер нь ямар зүйлүүд орж байна? Тэр хамтран амьдралын асуудлыг энэ хууль дээр оруулж ирж байгаа бас буруу. Оруулж ирэхдээ аль хууль дээр байх байсан юм? Энэ нь өөрөө эргээд ерөнхийдөө гэр бүл батлуулахгүйгээр явах ийм шаардлагууд үүсэж байна. Гэр бүлийг бүртгүүлэхэд харшлах шалтгаан буюу удамших өвчтэй гэдэг хоцрогдчихсон юм шүү дээ. Үр хүүхэдтэй болохгүй асуудал дээр л энэ дээр зөвлөгөө өгнө үү гэхээс биш энэ гэр бүл болоход харшлах шалтгаан биш байхгүй юу. Бид хэд ерөөсөө ингээд байгаа юмыг бас дүгнэлт хийгээд ороод.../минут дуусав.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Ургийн овгийн асуудал бол хүн ам зүйн, удам зүйн болон цус ойртолтоос сэргийлэх дээр энэ асуудал чухал. Тантай санал нэг байна. Яг хуулийн төслийг дагалдуулаад боловсруулсан хууль дээр энэ ургийн овогтой холбоотой энийг дагаж мөрдөх журмын хуулиар зохицуулсан зүйл орж ирээгүй. Хуулийн төсөл дээр ургийн овгийг хөтлөхтэй холбоотой ургийн овгийг хөтлөх болон мэргэжлийн энэ дэмжлэг үзүүлэхтэй холбоотой заавар аргачлалыг гэр бүлийн болон боловсролын асуудал эрхэлсэн сайд нар хамтран батлахаар тусгаж өгч байгаа. Одоо байгаа Иргэний улсын бүртгэлийн хуулийн зохицуулалтаар ургийн овгоо иргэд 1 удаа бас өөрчлөх энэ эрх нь бас байгаа.

Тэгэхлээр энэ байгаа зохицуулалтын хүрээндээ энэ ургийн овгийн өөрчлөх, цэгцлэх асуудлаа иргэд өөрсдөө шийдвэрлэх боломж байгаа гэж ингэж харж байна. Тээгч эхийн энэ асуудал яах аргагүй бас таны саяын хэлж байгаагаар гэр бүлийн шинэ харилцаанд тохирсон энэ зохицуулалтыг шаардаж байгаа энэ асуудал байгаа. Тэгээд энэ тээгч эхтэй холбоотой, донор бэлгийн эсийг ашиглан хүүхэдтэй болж байгаа тохиолдолд энэ хүүхдийн эцэг, эх байх эсэхийг нь энэ Гэр бүлийн хуулиараа тодорхой болгож өгч байгаа юм.

Донорын хуулиараа бол энэ тээгч эх болох тээгч эхтэй холбоотой гэрээний загвар батлах энэ зүйлүүд нь Донорын хуулиараа зохицуулагдаад одоо практикт явж байгаа. Гэр бүлийн хууль дээрээ энэний эцэг, эх нь хэн байх юм бэ гэдгийг нь илүү тодорхой болгоод өгч байгаа. Мөн гэрлэлтийн гэрээний асуудал бол одоогийн хүчин төгөлдөр хууль дээрээ агуулгаараа байдаг бол яг гэрлэлтийн гэрээ гэдэг нэр томъёогоор нь илүү түлхүү нарийвчилж энэ зохицуулж өгч байгаа. Гэрлэлтийн гэрээн дээрээ юуг тусгах ёстой юм, гэрлэлтийн гэрээнд хориглох зүйл нь байх юм гэдгийг энэ хуулийн төслөөр тодорхой болгож өгсөн байж байгаа.

Асралт гэр бүлд бас тавигдах шаардлагуудыг хуулийн төслийн төсөлд тусгасан байж байгаа. Тухайлбал, асралт гэр бүлд орлоготой байх ёстой, мөн эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх ёстой, мөн эцэг, эх байх үүргээ хасуулж байгаагүй байх гэх мэт асралт гэр бүлд тавигдах энэ хуулийн зохицуулалтыг төсөлд тусгасан байгаа.

Хамтран амьдрагчийн асуудал бас энэ хүүхдийн эрх ашгийг хамгаалах энэ зорилгын хүрээнд энэ хамтран амьдралтай холбоотой зохицуулалт энэ хуулийн төсөлд орж ирсэн юм. Таны илэрхийлж байгаа хамтран амьдралын асуудал энэ хуульд байх ёсгүй гэдэг зүйл дээр би ажлын хэсэг дээр бид нар энийг орох ёстой юм байна гэж ингэж оруулж ирсэн явж байгаа.

Удамших болон сэтгэцийн энэ өвчтэй хүн бол асуудал.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Хэдүүлээ энэ ажлын хэсэг гараад мэдээж явах байх. Тэгэхдээ ер нь ургийн овгийн асуудлыг 1 удаадаа өөрчлөх энэ дагаж мөрдөх шилжилтийн зохицуулалт хийх нь зөв. Наад 1 удаа өөрөө солиод явна гэдэг аймаар их чирэгдэлтэй. Хоёрдугаарт зөвхөн эцэг, эхийн нэр, өөрийн нэр сольдог байхгүй юу. Ургийн овог дээр бас тодорхойгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийгээ бас зөв ойлгоно хэдүүлээ.

Хоёрдугаарт энэ гадаад улсад үрчлүүлж байгаа хүүхдийн асуудал дээр бас дэлгэрүүлэх гэж оролдсон боловч одоо яг л байгаа түвшинд ингээд яг тэр чигт нь тавьчихжээ. Энийг илүү их жоохон нарийвчлах асуудал байсан юм. Ялангуяа Монгол Улсын иргэнээс төрсөн хүүхдүүдийг гадагшаа үрчлүүлэх энэ бодлогыг ер нь жоохон хязгаарлах талдаа байх ёстой юм. Ер нь бас хүний эрхийн асуудал боловч тэгэхээр энэ дээрээ бас жоохон бодолтой, суурь дүгнэлтүүдийг яаж гаргах вэ гэдгийг илүү их тодруулах шаардлага байгаа.

Хоёрдугаарт, яах вэ энэ үр дагаврууд байгаа юм. Асралт гэр бүл болон энэ эцэг, эх байх эрхийг хасах энэ асуудлын цаана төр ямар буюу орон нутаг ямар үүрэг хүлээх вэ гэдэг дээр түрүүн зардал асуугаад байгаа юм. Энэ дээр яг тодорхой хэлээч.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд асуувал асуучих. Тэгье. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Түрүүн Пүрэвдаваа гишүүн яг асуух гээд байх шиг байна лээ. Тэгээд Аубакир гишүүнээс, сайдаас оруулж ирэх гэж байгаа гэж ойлгосон. Төрөөс гэр бүлийг дэмжих тухай хууль буюу дээрээс нь энэ хүүхдийн эрхийг хамгаалах багц хуулиудтайгаа уялдуулаад яг энэ “foster family” тэгээд эцэг, эх байх эрхийг хассаны үр дагавар буюу тэр асрамжийн газар энэ зүйлүүдийн санхүүжилт, менежмент, тэд нарын үйл ажиллагааг ил тод байлгах аас эхлээд энэ асуудлууд бас энэ ултай суурьтай, цэгцтэй авч явах ёстой. Нэг ийм юм хийгээд өгчихдөг шүүх шийдвэр гаргадаг хүлээж авах байгууллага байхгүй. Жишээ нь “foster family” хэрхэн яаж сонгон шалгаруулах, хэн мэдээллийн санг нь үүсгэх энэ тэр гээд тодорхой хуулийн энэ зохицуулалтууд харагдахгүй байна. Нэгдүгээрт.

Энэ бүтэн өнчин хүүхдүүдийн энэ асрамжийн газарт байгаа хүүхдүүдийн эд хөрөнгийн эрх маш их зөрчигддөг. Энэ дээр судалгаа өгөөч. Яг энэ 18 нас хүрээд асрамжийн газраасаа гарч байгаа хүүхдүүд дансандаа болоод ямар хөрөнгөтэй гарч байна? Заримдаа сэтгэцийн өөрчлөлттэй гэдгээр яагаад ах, дүү нар нийлж байгаад нэгийгээ ийм шинжилгээний дүгнэлт гаргуулж байгаад байр савыг нь аав, ээжээс нь өгсөн юм.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон хариулах уу? Мягмар дарга өөр хүнээр нэмж хариулуулах бол хэлээрэй.

Н.Мягмар: Гэр бүлийн яамнаас ажлын хэсэгт байгаа. Ялангуяа энэ асрамжийн газар дахь дансны мөнгө энэ тэртэй холбоотой мэдээлэл байвал Гэр бүлийн яамнаас хариулъя.

Энэ Гэр бүлийн хуулиар бид нар яг Сайнзориг гишүүний ярьдаг энэ хувийн эрх зүйн харилцааг зохицуулсан зохицуулалтаа түлхүү оруулж ирж байгаа учраас яг энэ асралт гэр бүлд олгох төрөөс олгох урамшуулал гэдэг юм уу, дэмжлэг гэдэг юм уу тэр зүйл энэ тэр энэ хуульд тусгагдаагүй. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд тусгагдана гэдэг ийм үзэл баримтлалын хүрээнд ойлгож байгаа.

Гэр бүлийн хууль дээр гэр бүлийн гишүүд хүүхдийн хуваарьт хөрөнгийн асуудлыг зохицуулж өгч байгаа. Тэгэхлээр яг таны саяын дурддаг асрамжид байгаа хүүхэд төрөөс олгож байгаа гэдэг юм Эрдэнэс Тавантолгойн хувьцааны мөнгө төгрөг ч гэдэг юм уу энэ зүйл бол.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулах уу? 4 дүгээр микрофон гүйцээгээд хариулъя.

Н.Мягмар: Ийм яг тухайн хүүхдийн хуваарьт хөрөнгийг эцэг, эх нь хүүхдийн эрх ашгийн эсрэг дур мэдэн зарцуулахгүй гэдэг ийм хориглосон зохицуулалтуудыг орж ирж байгаа. Энийг зөрчсөн тохиолдолд хүүхэд өөрөө бас шүүхэд хүсэлт гаргаж энэ хохирлоо нэхэмжлэх эрхийг нь насанд хүрсэн хойноо гаргах тэр эрхийг нь олгочихсон байгаа.

Д.Цогтбаатар: Гэр бүлийн яамнаас энэ дээр гүйцээж хариулах. 6 дугаар микрофон дээр очоод суучих. Өөрийгөө танилцуулаад хариултаа хэлээрэй.

М.Цогтбаатар: Сайн байна уу Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ахлах шинжээч. Тэгэхээр манай яамнаас Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг үзэл баримтлалыг өмнө нь 2 удаа батлуулсан. Одоо 3 дахиа батлуулах гээд ажиллаж байна. Ерөнхийдөө 6 сард өргөн барьсан өмнөх Засгийн газрын үед тэгээд буцаан татагдсан байгаа.

Саяын асуултуудын хүрээнд асралт гэр бүлийн зохицуулалтыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлд бүрэн тусгагдсан. Хүүхдийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг эхлээд төрөл садны асаргаанд, гэр бүлийн орчинд, тэндээс боломжгүй гэж үзэх юм бол асралт гэр бүл тэгээд тэндээс боломжгүй бол асрамж, халамжийн газарт харьяалуулах, үйлчилгээ үзүүлэхээр заасан байгаа. Асралт гэр бүлд үзүүлэх журмыг мөн манай яамны зүгээс баталсан. Тэгэхээр энэ дээр бас шалгуурууд, үзүүлэлтүүд байгаа. Одоогоор бол

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Хэд хэдэн багц асуулт байна. Гэр бүлийн тухай хууль дээр гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх, бүртгэхтэй холбоотой ялгаварлан гадуурхалт дээр ямар ахиц дэвшил гаргаж байгаа вэ гэдэг асуулт байна. Учир нь гэвэл НҮБ-аас 2015 оны онд Монгол Улсад Засгийн газарт зөвлөмж өгсөн. Энэ дээр ялангуяа

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал, дээр гэр бүлийн асуудал дээр, нийгмийн оролцооны асуудал дээр маш их 37 ийм зөвлөмжийг Монгол Улс авсан байгаа. Тэгээд эдгээрийг зассан уу үгүй юу гээд ингээд харахлаар бас засагдаагүй харагдаад байна. Энэ дээр хариулт авмаар байна.

Ялангуяа сэтгэц болоод оюуны бэрхшээлийг бид нар нэг ангилалд оруулчихдаг. Сэтгэц болоод оюуны бэрхшээлтэй хүмүүс гэр бүл зохиох, үр хүүхэдтэй болох, хүүхэд үрчилж авах гээд энэ бүгдийг бүгдийг нь ингээд хориглочихсон хэвээрээ орж ирээд байна. Тэгээд энэ нөхцөл байдлыг яагаад ингэж үнэлээд байгаа вэ гэдэг асуултыг авъя.

Аутизмын болоод дауны хам шинж гээд эд нар чинь бүгдээрээ ялгаатай ойлголтууд шүү дээ. Бид нар бүгдийг нь дандаа нэг уутанд хийчхээд байдаг. Тэгээд нийгмийн үндсэн нэгжтэй бид нар энэ гэр бүлийн хүмүүсийг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхаад байгаа нь өөрөө болж байгаа гэдэг нэг ийм багц асуулт байна.

Хоёрдугаарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч халамжилж үлдэж байгаа тохиолдолд асран халамж, түүнтэй холбоотой гарч байгаа зардал, тэтгэлгийн асуудал дээр ялгамжтай байдлаар зохицуулж байгаа юу, яг адилхан оруулж ирж байгаа гээд? Үүнтэй холбоотой бас судалгаанууд хийгдсэн үү гэдэг ийм асуулт байна.

Гуравдугаарт, хүүхдийн асран хамгааллын асуудлыг илүү өргөн хүрээнд хараач гээд НҮБ-аас Хүүхдийн эрхийн хорооноос зөвлөдөг. Манай улс яах вэ уламжлалт байдлаар асран хамгааллыг харж байгаа. Би бас өмнө нь шүүхийн хэлэлцүүлэгт оролцож байхдаа бас хэлж байсан. НҮБ-аас 24 цагаас дээш хугацаанд хүүхэд эцэг, эх өөрийнхөө орон байрнаас гадуур хол байх юм бол асран хамгаалал өөрчлөгдөж байна гэж үздэг болсон байгаа.

Гэтэл Монгол Улсад дотуур байр гэж аягүй том асуудал байгаа тээ? Тэгэхээр дотуур байранд байгаа хүүхдийн асран хамгаалал яах вэ, гэр бүлдээ эцэг, эх нь асран хамгаалагч хэвээр байх уу? Гэтэл хүүхэд гэр бүлээсээ хол, эцэг, эхийнхээ хараа хяналтаас хол 200 гаруй хоног ингээд дотуур байранд байгаад байна. Олон асуудлууд үүсдэг. Тэгэхээр энийг ерөөсөө бид нар огт зохицуулж ирж чадахгүй яваад байгаа. Энэ манай өөрийн онцлог. Энэнтэй холбоотой, бас асран хамгаалалттай холбоотой ахиц дэвшил ямар зүйл байгаа вэ гэдэг асуулт байна.

Дөрөвдүгээрт, гэр бүлийн олон янз байдлыг ер нь энэ хуулиар гэж харж байгаа вэ? Бид нар уламжлалт байдлаар гэр бүлийг харж байгаа. Тэгвэл гэр бүл цуцлах, гэр бүлийн хэн нэг нь хагацах, нас барах өөр ахмадуудтайгаа хамт амьдрах гээд гэр бүлийн олон янз байдлууд байдаг. Тэгэхээр бид нар дандаа ийм уламжлалт хандлагаараа энэ хуулийг харж байгаа юу? Гэр бүлийн олон янз байдлыг яаж хүлээн зөвшөөрч байгаа вэ гэдэг асуулт байна.

Хамгийн сүүлд иргэний нийгэм, төрийн бус байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг ер нь энэ Гэр бүлийн хууль дээр яаж харж байгаа вэ? Концепцын хувьд өөрчлөлт орж ирж байгаа юу, оролцооны асуудал хэр орж ирж байгаа вэ? Ялангуяа гэр бүлийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Н.Мягмар: Ялгаварлан гадуурхалттай холбоотой асуудал Монгол Улсын Үндсэн хууль болоод бусад хуулиудаар энэ ялгаварлан гадуурхахыг бүх түвшиндээ ялгаварлан гадуурхалтаас ангид байх энэ агуулгаар боловсруулагдаж байгаа. Тэгэхлээр энэ Гэр бүлийн хууль ч гэсэн, шинэчилсэн найруулга ч гэсэн энэ ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчмын хүрээнд боловсруулагдсан гэж ойлгож болно.

Саяын таны дурдаж байгаа гэр бүлийг бүртгэхээс харшлах шалтгаан гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл сэтгэцийн өвчтэй гэдэг юм уу энэ зүйлийг нэг уутанд хийхээд байна гэдэг зүйлийг та ярьж байна. Хуулийн төслийн бол 8 дугаар зүйлд гэрлэхэд харшлах нөхцөлүүдийг зааж өгсөн. Энэ дээр саяын таны дурдаж байгаагаар гэрлэхийг хүсэгчдийн хэн нэг нь, эс үгүй бол хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй гэж байгаа юм. Тэгэхлээр энэ маань үндсэндээ гэр бүлийн удмын сан, Монгол хүний гений аюулгүй байдал энэ тэртэй холбоотой.

Нөгөө талаасаа энэ гэрлэхийг хүсэгчдийн маань үүргээ хүлээн зөвшөөрөх энэ асуудал дээр өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй байх ийм хэмжээний архаг өвчний асуудлыг гэрлэхэд харшлах нөхцөлд оруулж өгч байгаа. Тэрнээс бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлийн юугаар ялгаварлан гадуурхах ийм зохицуулалт байхгүй.

Дотуур байранд байгаа хүүхдийн асран хамгаалалтын асуудал ярьж байна. Дотуур байрны асуудал бол энэ боловсролын салбар дахь асуудал учраас энэ Гэр бүлийн харилцаан дахь асран хамгаалах харгалзан дэмжлэгийн асуудал энэ дотуур байрны байранд байгаа сурагчдын гэдэг юм уу, энэ сурч боловсрох байгууллагын орчинд сурч байгаа хүмүүсийн амьдрах нөхцөлийг хангаж байгаа энэ байранд энэ Гэр бүлийн хуулийн асран хамгаалан харгалзан дэмжлэгийн асуудал бол хамаарахгүй. Гагцхүү сургуулийн захиргааны зүгээс энэ боловсролын хүрээндээ тэр үүрэг хүлээсэн ажилтан, албан хаагчид нь энэ дотуур байрны аюулгүй байдлыг хангах энэ чиг үүргээ хүлээж ажиллана гэж ингэж харж байна.

Гэр бүлийн олон янз байдлын хувьд мэдээж Монголд гэр бүл нь ахмад настнаа, эцэг, эхээ асран тэжээдэг, хөгжлийн гэдэг юм уу эсвэл асаргаа шаардлагатай улсуудтайгаа хамт амьдардаг энэ зохицуулалтууд бол одоогийн Гэр бүлийн хуулиар ч бий. Шинэ зохицуулалтын хуулиар ч гэсэн энэ гэр бүлийн гишүүд гэдэг тодорхойлолтууд оруулаад явж байгаа. Тэгэхлээр энэ дээр тэжээн тэтгэх үүргүүд нь гэрлэгчдийн асуудал шинэчилсэн найруулгадаа байгаа учраас энэ үүргүүд хэвээрээ явна. Гэр бүлийн олон янз байдлын асуудлууд.

Д.Цогтбаатар: Нэмж хариулах уу? Баасанжаргал гишүүн. 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэлгийн асуудал гээд ярьж байна. Энэ хүүхдийн тэтгэлгийн асуудал энэ хуулийн шинэчилсэн найруулгын юун дээр бол амьжиргааны баталгаажих түвшнээр олгодог энэ зохицуулалтыг өөрчлөөд хүүхдийн хэрэгцээ шаардлага, онцлог болон хүүхдийн тэтгэлэг төлөх тэр хариуцагчийн орлоготой уялдуулаад шүүхээс тогтоож, өөрөөр тогтоож болохоор заасан байгаа юм. Тэгэхлээр энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд жишээ нь тэтгэлэг нь илүү асаргаа шаарддаг ийм байх юм бол тэр онцлогт нь тохируулаад тэтгэлэг

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

төлөгчийн орлоготой нь уялдуулаад шүүх энэ тэтгэлгийн хэмжээг тогтоох энэ боломжийг энэ шинэчилсэн найруулгын хүрээнд оруулж ирж байгаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Миний гол хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал дээр гол асуугаад байгаа асуулт маань энэ л дээ. Жишээ нь аутизм болоод дауны синдромтой хүмүүсийг бид нар бүгдийг нь дандаа сэтгэцийн өвчтэй гэдэг ангилал руу оруулчихдаг. Гэтэл аутизм нийгэмшлийн асуудал байгаад байдаг. Дауны синдром бол хөгжлийн хоцрогдол байгаад байдаг. Ингээд ялгаатай байдаг. Тэдний нийгэмтэй харьцах харилцаа хүртэл өөр байгаад байдаг. Бүгдийг нь нэг уутанд оруулаад л.

Жишээ нь энэ хуулийн төслийн 66.3 дээр ч гэсэндээ 66.3.7 дээр сэтгэцийн өвчтэй эсвэл согтууруулах ундаа гээд ийм хүмүүсийг хүүхэд үрчилж авахыг хориглоно ч гэдэг юм уу ийм заалтууд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд ерөөсөө ингээд нийтээр нь бид нар сэтгэцийн өвчтэй гэдэг нэрийн доор бүх энэ бусад оюуны бэрхшээлийг бүгдийг нь оруулчихаад байгаа асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энийгээ бид нар ялгаатай харах ёстой. Энэ дээрээ бид нар маш олон удаа НҮБ-аас зөвлөмж, шаардлага авсан шүү дээ. Та хэд маань аягүй сайн мэдэж байгаа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Нэмээд 1 минутаа шууд авчих.

Х.Баасанжаргал: Хоёрдугаарт гэвэл гол бас нэг зүйл болохлоор хөдөлмөрийн чадвар алдалт, хөгжлийн бэрхшээл эд нарыг бас ялгаатай зохицуулах хэрэгтэй байгаад байдаг. Хөдөлмөрийн чадвар алдалт, хөгжлийн бэрхшээлийг бид нар бас дахиад л нэг уутанд хийчихсэн яваад байгаа юм. Энэ болгоныгоо бид нар ялгаатай зохицуулахгүй бол хамгийн гол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдралд оролцох эрхийг Гэр бүлийн хууль маань өөрөө хязгаарлаад байгаа гэдгийг бас бүгдээрээ сайн мэдэж байгаа байх гэж бодож байна. Тэгээд энэ дээр ерөөсөө тийм ахиц дэвшил гэдэг юм уу одоогийн байгаа хүчин төгөлдөр хуулиас ялгаатай байдлаар зохицуулсан зүйл төдийлөн харагдахгүй байгаа учраас ийм саналыг хэлээд байгаа юм.

Хамгийн сүүлд нь тэр гол нь иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын оролцоо ялангуяа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай энэ маань яаж уялдаж байгаа вэ? Хууль нь өөрөө хэвээрээ байгаад байдаг. Хөгжлийн дэмжих тухай хууль нь бас орж ирээгүй байгаад байдаг гээд. Уг нь ингээд болж өгвөл энийг нэг системээр нэг цогцоор нь хармаар байгаа байхгүй юу. Гэтэл тэр бусад хүчирхийллийн асуудал, Хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь өөрөө ахиц дэвшил байхгүй. Эвлэрүүлэн зуучлалын асуудал ахиц дэвшил байхгүй бол мянга энэ хууль яваад нэмэргүй л болох гээд байна л даа. Тэгэхээр энийг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон хариулах уу? Мягмар дарга.

Н.Мягмар: Сүүлийн асуултуудаас нь хариулъя. Гэр бүлийн хүчирхийлэл болон Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль энэ зөрчилтэй холбоотой энэ асуудлуудыг хөндөж байна. Тэгэхлээр энэ хуулийг дагалдуулаад бид нар бас зөрчлийн хуулиуд дээр энэ гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал үүссэн

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тохиолдолд Гэр бүлийн хуулиараа эвлэрүүлэн зуучлах гэдэг юм уу энэ хугацааг олгохгүйгээр шууд шүүхээр цуцлах буюу тэр нэхэмжлэлээ гаргах ийм бололцоог нь бас нээж өгч орж ирж байгаа.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль удахгүй орж ирнэ гэж ингэж тооцож байгаа. Тэгэхлээр энэ хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн тохиолдолд Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуультай уялдуулаад анхны хэлэлцүүлэг энэ тэрийг нь хийгээд явах боломжууд бүрдэх байх гэж ингэж харж байна.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Өнөөдөр их ийм чухал хууль орж ирж байгаа юм. Гэр бүл нийгмийн анхдагч нэгж. Олон жил энэ гэр бүлийн асуудал тойрсон маргаан шүүхийн их төвөгтэй асуудал байж ирсэн юм. Ер нь ингээд гэр бүлийн хэрэг дээр өмгөөлөл хийгээд л явахад ер нь мэдэгддэг. Субъектив шийдэх зүйлүүд ихтэй, материаллаг хэм хэмжээний дутагдалтай, процессын бас асуудалтай энэ асуудал дээр түрүүн манай Сайнзориг гишүүн хэлж байна бас нэлээн олон сайд дамжиж боловсрогдож орж ирж байгаа юм. Тэгээд ингээд хараад асуухаар зарим нэг ойлгомжгүй зүйлүүд, тодруулах, лавлах, сайжруулах юмнууд байж мэднэ. Байгаа ч байх. Тэгэхдээ хэдүүлээ одоо цаг хугацааны хувьд энэ хуулийн төслүүдийг хэлэлцээд, сайжруулаад, хурдан батлаад явах нь нийгэмд их тулгамдаж байгаа асуудал шүү гэдэг нэгдүгээр асуудал. Зориуд гишүүддээ хэлж байгаа юм.

Ер нь энэ хуулийн төслүүдийг сайхан дэмжээд хэдүүлээ хэлэлцээд тэгээд ажлын хэсэг дээрээ сайжруулах зүйлийг нь сайжруулаад, статистик тоо баримтаа нийлүүлээд ингээд явмаар байна. Маш хурдан бид нар батлах ёстой хууль шүү гэж.

Асуултын хувьд би Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Золоо шүүгчээс асууя. Энэ гэр бүлийн шүүхтэй холбоотой нөхцөл байдал маань өнөөдөр ер нь ямар байгаа вэ? Процессын хууль маань ингээд ер нь орж ирж байна? Ер нь энэ гэр бүлийн шүүх шүүхэд ямар ач холбогдолтой гэж үзэж байна? Ач холбогдол нь ер нь юун дээр байна гэж ингэж үзэж байна гэдэг нэг асуулт.

Алтанчимэг шүүгчид ирчихсэн байсан. Ер нь энэ эдгээр хуулиуд батлагдаад явах юм бол цаашдаа Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дагуу энэ эдгээр маргаан, асуудлууд ингээд шийдвэрлээд явахад яг тусдаа процессын хуультай, Гэр бүлийн хууль нь сайжирчихсан байх нь ер нь ямар ач холбогдолтой гэж, шүүхэд маргаан шийдвэрлэхэд ямар ач холбогдол гарна гэж та бүхэн үзэж байгаа вэ? Ямар давуу талтай болох вэ гэсэн эдгээр асуултуудад хариулт авъя.

Д.Цогтбаатар: Хэддүгээр микрофон дээр суух вэ та? 6 дээр суучихъя. 6 дугаар микрофон өгье. Золзаяа гишүүн.

П.Золзаяа: Гэр бүлийн шүүхийг байгуулах учир холбогдол, ач холбогдлын талаар маш олон ярьсан. Ер нь товчхондоо хэлэхэд өнөөг хүртэл явж ирсэн шүүхийн практик бол ерөнхийдөө шийдээд л явдаг. Яг үнэндээ ямар байх ёстой вэ гэвэл яагаад энэ гэр бүл салдаг юм, асуудал нь юундаа байдаг юм, нийгмийн, эдийн засгийн бүхий л суурь зүйлийг үздэг, тогтоодог, дүн шинжилгээ хийдэг ингэж бүхэлд нь харсан ийм шийдэл байх ёстой. Энэ шийдлийг бид нар өнөөдрийг хүртэл гаргаж явж чадаагүй. Одоо энийг ингээд утгаар нь энэ хууль, дагнасан

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хуулийг бий болгож, бие даасан хуулийг бий болгож дагнасан шүүхээр шийдүүлж энэ нийгэмд гүйцэтгэх үүрэг тэр байх ёстой асуудлыг энэ хэмжээнд байх ёстой гэдэг агуулгаар эхнээсээ ингээд явж байгаа.

Одоогийн байдлаар гэр бүлийн шүүгч бол дагнасан шүүхэд мэргэжлийн ийм хүмүүс байх ёстой гэдэг үүднээс шүүгчийн сонгон шалгаруулалтаа явуулж байна. Ер нь тэнцсэн хүн цөөхөн. Гэхдээ энийг нөхөх арга байгаа. Бусад ажиллаж байгаа шүүгч нараас шилжүүлээд шүүгч нарыг бүрдүүлэх боломж байгаа. Тэр бол байж байна. Яг үйл ажиллагаа явуулах өөрийн байр ямар байдалтай байна вэ гэдэг дээр асуудалтай бий. Тэгэхдээ энэ дээр ямар ч байсан анхан шатын шүүх, давж заалдах шатын шүүхийн байрыг сонгочихсон ингээд тэр засвар янз бүрийн ажлыг хийх гэж байгаа боловч ингээд төсөв нь яг энэ оны сүүлд ингээд хураагдчихдаг юм байна. Тэгээд л одоогийн байдлаар ерөнхийдөө тендер зарласан, гэрээ байгуулах хэмжээнд явж байгаа ийм байдалтай байна.

Захиргааны ажилчдын тухайд сая ярьж байна. Яг мэргэшсэн маш олон энэ Гэр бүлийн тухай хуулийг дагаад маш олон, олон ч юу байх вэ нэлээн хэдэн орон тоо бий болж байгаа. Сэтгэл зүйч, нөхцөл байдлын үнэлгээ хийдэг хүмүүс тэгээд эвлэрүүлэн зуучлалтай холбоотой захиргааны бусад ажилтнууд ингээд бий болж байгаа. Тэр орон тооны хувьд мөн тооцоолоод ингээд төлөвлөөд явсан юм байна лээ төсөвтөө. Тэгтэл бас зарим зүйл дээр ингээд хасагдчихсан байх жишээний. Бас яг ингээд ийм бэрхшээлүүд ингээд, яг ингээд хэрэгжих нөхцөлийг нь хангах гэхээр бас ингээд төсвөөр нь ингээд хасчихсан ийм тохиолдлууд одоо ингээд гараад ирчихсэн байдаг юм байна. Энийг ингээд судлаад явж байна. Одоо би байгаа байдлаар нь л хэлье гэж бодож байна. Тийм.

Д.Цогтбаатар: Нэмж тодруулах уу Алтангэрэл? Алтанчимэг шүүгчээс 1 номер. 1 номерын микрофон өгье. Улсын дээд шүүхийн шүүгч.

Г.Алтанчимэг: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Гэр бүлийн шүүх дагнаж байгуулагдсанаар, Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын хууль дагнаад батлагдсанаар ямар ер нь ач холбогдол, үр дүнг харж байна вэ гэсэн ийм агуулгатай асуулт байна гэж ойлголоо. Ер нь энэ олон улсын жишгээр явж байна гэж нэгдүгээрт нь хэлмээр байна. Олон улсад гэр бүл, хүүхдийг хамгаалах энэ ажиллагаа бол бас дагнасан шүүх, мэргэшсэн шүүгчийн хэмжээнд явж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, манай иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон төрлийн харилцаа явж байгаа. Энэ харилцаанаас бас тасалж аваад дагнаад ингээд гэр бүлийн шүүх, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа өөр зарчмаар явуулах юм бол бас хамгийн нэгдүгээрт гэр бүлийг аварч үлдэх, тэр дотор байгаа хүүхдийн эрх ашиг гэдэг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон гүйцээгээд хариулъя.

Г.Алтанчимэг: Хамгаалагдах энэ үр дүн нь гарна гэж ингэж л харж байгаа юм. Тэгэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны одоо бид нар иргэний процессын хуулиа хэрэглэж байгаа. Процессын хууль дотор гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг тусдаа бүлэг байдаг. Тэгэхдээ тэр бүлгээр бас төдийлөн сайн журамлаж чадаагүй байгаа. Энэ шинэ хуульд бас ерөнхийдөө иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа диспозитив зарчмын үндсэн дээр

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

явдаг. Одоо энэ гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын хуульд хүүхдийн эрхийг хамгаалах, мөн түүнчлэн шүүх санаачилгаар оролцох зарим асуудал дээр гэдэг ийм зарчим өөрөө шал өөрөөр томъёологдож ирж байгаа. Гэр бүлийг аврах гээд түрүүн би ярилаа энд гэр бүлийн хэрэгтэй ажиллах тусдаа баг бий болно, ажиллах процесс нь арай илүү нарийн болно гэдэг ийм л процессын хууль явж байна гэж хараад байна. Одоогоор ийм хариулт өгье.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд Алтангэрэл гишүүн. Микрофоныг нь өгье.

О.Алтангэрэл: Яг л сонсохыг хүсэж байсан хариултыг л өгч байна л даа. Бид нар ер нь энэ гэр бүлийн тухай асуудал ярихдаа яг энэ сая манай Алтанчимэг шүүгчийн хэрэглэж байгаа гэр бүлийг аврах гэдэг энэ үгийг бас бид нар нэлээн хэрэглэж, хэвших ёстой юм байгаа юм. Тэр чигтээ маргаан руу, тэр чигтээ тэмцэл рүү явж болохгүй. Ер нь цаашид бид нар хууль байгаагийн зорилго юу билээ гэдгээ бид нар бас бодох ёстой болчихож байгаа юм. Тийм болохоор би бас дахиад гишүүдийг, гишүүддээ бас уриалъя. Эдгээр хуулийн төслүүдийг бид нар нэн даруй хэлэлцээд сайжруулах зүйлээ сайжруулаад цаашаагаа ингээд батлаад явах нь их зүйтэй байна. Энэ асуудал дээр бас нэлээн идэвхтэй оролцоосой гэж гишүүдээсээ хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Би ганц, хоёр асуулт асууна. Нэг ийм юм асуумаар байна. Энэ хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр 5.3, 5.5 хоёр дээр ийм асуулт байна л даа. Энэ 5.3 дээр энэ гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө янз бүрийн өвчтэй, эмгэг согогтой байна уу үгүй юү гэдгээ урьдчилан шинжилгээ өгч, тодорхойлолт гаргуулан авсан байна гээд. Энэ бол ингээд үүргийн шинжтэй болчихож байгаа юм. Тэгэнгүүт 5.5 дээр болохлоор ДНХ-ийн бас удам зүйн шинжилгээнд хамрагдаж болно гээд.

Тэгэхлээр энд энэ 5.3 дээр жишээлбэл удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй эсэхийг ингээд тогтоох, өөрөөр хэлбэл тэртээ тэргүй ДНХ-ийн шинжилгээ өгч байгаа байхгүй юу. Энийгээ хамтатгаж хийж болдоггүй юм уу? Эс үгүй бол зардал талаасаа энэ дээр өөр ялгаа гараад байгаа учраас ингэж салгаж бичсэн юм уу? Тэгэхлээр 5.5 дээр хэрэв нэгэнт ингэж салгаж бичих хэрэгтэй бол 5.5 заавал байх шаардлага байна уу? Яагаад гэвэл болно гээд. Тэртээ тэргүй хүмүүс дуртай бол өөрсдөө сая Мягмар даргын ярьж байгаагаар өөрсдөө зардлаа гаргаад хийлгэнэ гээд байна шүү дээ. Тэгэхлээр тэртээ тэргүй иргэд өөрсдөө ингээд хийж болох юмыг энд заавал ингэж болно гэж тэгж зааж өгөх байна уу хэрэгцээ?

Хоёрдугаар асуулт нь юу вэ гэхлээр энэ 9 дүгээр зүйл дээр нэг асуудал байна л даа. 9.3 дээр гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах үүрэг хүлээнэ гээд, 9.3.4 дээр угийн бичиг хөтлөх, өвлүүлэх гэж байгаа юм. Энэ уг нь аягүй чухал заалт. Гэхдээ би эндээс нэг юм асуумаар байна. Энэ чинь яг тодорхой үүрэг өгч байгаа, энэ үүрэг үүрүүлж байгаа заалт байгаа байхгүй 3.9.3.4 чинь. Ингээгүй бол ямар хариуцлага хүлээх вэ? Одоо энийг хөтөлнө өө, угийн бичгээ хөтөлнө өө гэхчхэн. Тэгээд энийгээ хөтлөөгүй байвал яах ёстой болж байна? Тэгээд энэ дээр миний тэр ДНХ-ийн шинжилгээ энэ 5.3 дээр шинжилгээ эд нар дээр нэг ийм асуудал байна. Хаа хол байсан аймгийн нэг сумын баг дээр амьдарч байгаа хоёр гэрлэх болоод ирсэн чинь энэ 5.3 дээр заавал ийм шинжилгээнүүд өгсөн байх ёстой гээд энэ шинжилгээний нарийвчлал нь мэдэхгүй лав тэр сумд хийхээргүй шинжилгээ байгаад байна л даа. Тэгэхлээр тэр хол байгаа хүмүүс чинь заавал

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

энийг хийх хэрэгтэй болж таарах уу? Тэгвэл хот орж ирж хийлгэх юм уу? Ялангуяа энэ ДНХ-тэй холбоотой шинжилгээг? Энэ дээр ямар хариулт байна.

4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ 5.3 дээр байгаа сэтгэцийн архаг өвчтэй эсэхээ тогтоох эрүүл мэндийн шинжилгээг гаргуулан авсан байна гэдэг энэ зохицуулалт сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын шинжилгээ байгаад байгаа юм. 5.5 дээр байгаа ДНХ-гийн шинжилгээ нь болохлоороо сэтгэц биш удам зүйн буюу садан төрлийн холбоотой эсэхийг нь тогтоох ийм 2 өөр зорилготой 2 өөр агуулга байгаа. Сэтгэцийнх нь заавал шинжилгээ хийх. Өөрөөр хэлэх юм бол ийм архаг өвчтэй байх юм бол гэрлэхэд харшлах шалтгаан гээд заагаад өгчихсөн учраас энэ лавлагаа, тодорхойлолтыг авч байж гэрлэлт бүртгүүлэх нөхцөл үүсэх юм. Тэгэхлээр энийг заавал хийлгэнэ.

Харин тэр удам зүйн шинжилгээ бол иргэд, гэрлэхийг хүсэгчид өөрсдөө хүсвэл болон сонирхогч талын хүсэлт, шаардлагаар энийг хийлгүүлж болно гэж байгаа юм. Энэ сайн дурынх юм.

Д.Цогтбаатар: Мягмар дарга би яг асуултдаа энийг чинь өөрөө хэлчихсэн шүү дээ. Тэгэхлээр энийг ингэж нэгтгэж болдоггүй юм уу? Тэгэхлээр таны хариулт зардал нь тусдаа учраас нэгтгэхгүй салгаж байгаа юм гэж байх шиг байна тийм үү? Яагаад гэвэл ДНХ дээр хийж байгаа судалгааг энэ хоёр шинжилгээ шууд хамт хийх боломжгүй өөрөө тус тусдаа зардалтай, тус тусдаа шинжилгээ учраас салгах ёстой гэж би хариуллаа гэж ойлголоо. Гэхдээ миний одоо асуултын нэг юу нь болохлоор ийм нарийвчлалтай юуг чинь заавал хийгдсэн байх ёстой гэхлээр тэр хөдөө бүүр орон нутагт сум дээр байж байгаа хүмүүс чинь заавал хотод орж ирж энийгээ хийлгэх хэрэгтэй болох уу?

Н.Мягмар: Сэтгэцийн тэр архаг өвчтэй эсэхийг тогтоох нь заавал учраас энийг хийлгэнэ. Энэ чинь зорилго нь өөр юм гээд. ДНХ-ийн буюу тэр удам зүйн шинжилгээ бол сайн дурынх юм. Энэ заавал хийх биш. Хэрвээ энийг хийлгээ гэх юм бол 2028 оноос энэ зохицуулалтыг мөрдөж эхлэхээр байгаа. Энэний бэлтгэл ажлыг хангах хүрээндээ одоо бүсүүдийн төвүүд дээр ийм боломжийг бий болгоно гэсэн төсөөлөл байж байгаа.

Гэхдээ энийг иргэд хүсэж байгаа бол тохиолдолд хийлгэх учраас төдийлөн ачаалал гайгүй болов уу гэж ингэж тооцож байгаа. Манай яг нарийвчилсан энийг нэг шинжилгээгээр хийлгэж болох эсэхийг манай Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн яг энэ ДНХ-ийн лабораторийн эрхлэгч байгаа. Тэрийг яг тэр шинжлэх ухааныхаа юугаараа нэг зэрэг хийж болдог эсэхийг нь хариулаад өгөхийг хүсье.

Угийн бичиг хөтлөөгүй бол ямар хариуцлага хүлээх вэ гэдэг энэ асуудал дээр энэ гэрлэгчдийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Гэрлэгчдийн хүлээх үүрэг дээр оруулж өгч байгаа юм. Тэгээд энэнтэй холбоотой угийн бичгийг хөтлөхтэй холбоотой зааварчилгаа, журмыг нь гэр бүлийн болон боловсролын асуудал эрхэлсэн сайд нар маань хамтарч

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

батлахаар ингээд зохицуулж өгч байгаа. Энийг хөтлөөгүй бол яах вэ гэдэг энэ асуудал дээр энэ яах вэ гэрлэгчдийн нэг ёсны журамт үүрэг маягтай л агуулгын энэ зохицуулалт юм. Тэгэхлээр яг хариуцлага тооцоод чи хөтлөөгүй байна ингэдэг ийм зүйл энэ хуулийн төсөл болон зөрчлийн хариуцлага хүлээлгэх зүйлүүд дээр байхгүй байгаа.

Д.Цогтбаатар: ДНХ-ийн талаар тэр юуг би асуултынхаа бол хариултыг энд авчихлаа. Гэхдээ ДНХ-ийн талаар тэр хөдөө орон нутагт байгаа хүмүүс сэтгэцийн холбоотой тэр заавал хийлгэнэ гэж байна шүү дээ. Тэрийг тэгээд хөдөө орон нутагтаа хийлгэх боломжтой юу, эс үгүй бол заавал хот руу орж ирж хийлгэх шаардлагатай болох уу?

6 дугаар микрофон сайн байна уу?

Б.Тэнүүн: Манай Шүүх шинжилгээний ерөнхий газар болохоор 21 аймаг, 8 хэсэг, 5 бүсийн төвтэй. Тэгээд яг эцэг тогтоох шинжилгээг энэ бүсийн төвүүдээрээ бүгдээр нь дамжуулаад авдаг. Төв дээрээ дотоодын шуудангаараа цуглуулаад бүх шинжилгээнүүдийг хийдэг. Тэгэхээр аль аймаг, дүүрэгт, аль аймагт байхаас үл хамааран энэ шинжилгээнүүд хийгдэх бүрэн бололцоотой.

Таны асууснаар сэтгэцийн шинжилгээ, удам зүйн шинжилгээ хоёрыг хамтран хийх бололцоогүй. Хоёр өөр төрлийн шинжилгээ учраас энэ яг нэг заалтаар ч юм уу хийгдэх ийм бололцоо байхгүй гэж хэлье.

Д.Цогтбаатар: Нэг юм тодруулаад асуучихъя Мягмар дарга. Одоо энэ угийн бичиг хөтлөх, өвлүүлэх энэ аягүй чухал заалт гээд би түрүүн хэлж байна шүү дээ. Тэгэхлээр одоо ингээд гэрлэлтээ бүртгүүлэхэд энэ мэдээлэл орж байгаа чинь Иргэний бүртгэлийн сангийн мэдээлэлтэй хамт уялдаж орж цаашаа архивлагдаж хадгалагдах уу? Дараа нь хэзээ нэгэн цагт хэн нэгэн хүн гарч ирээд дараагийн хоёр гэр бүл, хос болох гээд орж ирэхэд энэ мэдээлэл хоорондоо уялдсан иргэний бүртгэл дээр ч хаана ч гэсэн гарч ирэх тийм боломжтой байгаа юу? Эс үгүй бол тус тусдаа энэ мэдээллүүд мэдээллийн баазад хадгалагдах ёстой юм уу?

4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Тийм. Гэр бүлийн бүртгэлийн хуулиараа энэ иргэний ургийн овог болон эцгийн нэр, өөрийн нэр энэ тэр бүртгэгдээд Улсын бүртгэлийн нэгдсэн сандаа ороод явна. Тэгэхлээр энэ угийн бичиг хотод ургийн овгоороо ингээд явж байгаа энэ мэдээллүүд саяын таны хэлдгээр дараа нь өөр лавлагаа, тодорхойлолт гаргуулах, нэг ургийн улсууд байна уу гэдэг дээр энэ иргэний улсын бүртгэлээс лавлагаа тодорхойлолтуудаа гаргуулаад төрөл садныхаа мөн эсэхээ бас тодруулах ийм боломж бүрдэнэ.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа.

Үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Сайнзориг гишүүнээр тасаллаа. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Маш чухал хууль орж ирж байна. Бүүр хүн бүхэнд хамаатай, өрх, гэр бүлд хамаатай ийм хууль. Тэгэхээр

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

манай гишүүд энэ удаагийн Их Хурлын гишүүдийг би бас юун дээр гуйж уриалах гэж байна вэ гэхээр энэ хуулийг энэ парламентаар бид нар яаж ийгээд заавал батлуулах ёстой. Өмнө нь миний мэдэхийн бараг 4 парламентаар орж ирээд энэ хууль орж ирсэн юм шүү дээ. Өргөн баригдсан юм. Тэгээд батлагддаггүй байхгүй юу. Тэгээд янз бүр болно. Энэ удаа бол би ажлын хэсгийн даргаар эрэгтэй гишүүнийг томилоосой гэж хүсэж байгаа. Яагаад гэхээр заримдаа ингээд эмэгтэй гишүүд ахлахаар эрэгтэйчүүд ингээд маазраад л тэглээ ингэлээ гээд тэгэнгүүтээ сошиалаар bully-дэж эхэлдэг. Эмэгтэй гишүүд ийм тэнэг юм ярилаа ингэлээ тэглээ гээд. Тэгэхээр энэ эрэгтэй гишүүдээр нь ахлуулах хэрэгтэй. Энэ хуулийг маш сайн хэлэлцэх ёстой гэж би хэлэх гээд байгаа. Мэдэхгүй эрэгтэйчүүд яагаад гацаагаад байдаг юм. Яг батлах болохоор л зарим дээр нь ингээд л гацаагаад байдаг юм шүү дээ.

Би 2016-аас 20 оны хооронд бас энэ намынхаа эмэгтэйчүүдийн шугамаар улс орон даяар хэлэлцүүлгийг нь хийсэн. Энэ Гэр бүлийн тухай хуулийн хэлэлцүүлгийг хийгээд Их Хурлын тухайн үед манай Оюунхорол гишүүн, Нарантуяа гишүүнд ингээд хүлээлгэж өгч байсан. Энэ дээр 2 үндсэн чухал зүйл бүх газраас гарч байсан. Энэ юу гэсэн заалт гарч байсан бэ гэхлээр эрсдэлийн сан байгуулж болдоггүй юм уу гэдэг юм гарч байсан юм. Яагаад гэхлээр гэр бүл саллаа маргаашаас нь эхлээд тэр хүүхэд хоол идэх хэрэгтэй, маргаашаас нь эхлээд тэр хүүхэд хувцас өмсөх ёстой. Зардал гардаг.

Гэтэл шүүхээр шийдвэрлэгдтэл өчнөөн жил явна. Сүүлдээ тэр ээж бол явахаасаа бүүр ингээд халгаад бүүр явахаа больдог. Тэр шүүхийн шийдвэр дээр тэр ээжийн хамтраад тэр тэтгэмжийг олох асуудал дээр явдаг зүйл бараг байдаггүй. Харин тэр Алтангэрэл гишүүний нэг өргөн барьсан хууль байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль. Тэр юу болсон бол? Тэр хууль дээр энэ асуудлыг бас сайн шийдвэрлэж өгсөн байсан. Тэгэхээр тэрийгээ бас яг зэрэг хэлэлцүүлээд явах ёстой. Өөрөөр хэлбэл, энэ гэр бүл салсны дараа үүргээ биелүүлэхгүй байгаа хүмүүст ямар хариуцлага тооцох юм бэ, яаж энийг нь хурдан тэр тэтгэмжийг нь олгох юм бэ гэдэг дээр хамгийн чухал асуудал. Ерөөсөө энэ хуулийн гол амин сүнс гэж би хэлэх гээд байна.

Дээрээс нь хүмүүс ийм санал гаргаж байсан. Бүхэл бүтэн улс байна даа хамаагүй ээ 2, 3-хан тэрбум төгрөгөөр эрсдэлийн сан байгуулаад гэр бүл салсны дараа тэр тодорхой хугацаанд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ч юм уу тэр хүүхдэд тэр тэтгэмжийг олгож байгаад тэр мөнгө ааваас нь юм уу тэр дараа нь энэ гэр бүлийн тэр салсан хүнээс гаргадаг тийм зээлийн хэлбэр үүсээд тэрийг эргэж олж авдаг байхаар энэ бусад их олон оронд хэрэгждэг юм байна лээ. Эхлээд эрсдэлийн сангаас өгчхөөд дараа нь тэр ааваас нь ч юм уу, ээж нь ингээд олж авдаг. Бүүр зарим үед өгөхгүй бол хувь, хүүтэй олгодог ийм зүйл байгаа. Тэгэхээр энийг би сая үг хэлэх дээр амжсангүй. Чуулган дээр энэ асуултыг асууя. Энэ дээр яг сайн хариулт бэлдээд ирээрэй гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь яг ямар дэмжлэг үзүүлэх юм бэ гэдгийг бас чуулган дээр асууя. Унгар улс бол энэ Гэр бүлийн хуулиар гэр бүлийг дэмждэг хамгийн сайн жишигтэй орон гэж яваад байгаа. Тэгэхээр энэ гаднын энэ туршлагыг хэр судалсан байдаг юм бэ? Тэгээд энэ хүүхэд өмчгүй үлдээд байдаг асуудлыг бас хэр сайн тусгаж өгсөн бэ гэдгийг чуулган дээр асууя. Энэ дээр байна. Хүүхдүүд гэр бүл салсны дараа насанд хүрээгүй учраас тэр хөрөнгийг нь өөр .../минут дуусав./

Д.Цогтбаатар: Нэмэх үү? Нэмээд хариу. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Хэлэлцэх эсэхийг дэмжинэ. Энэ бас олон жил яригдаж байгаа ингээд ороод ирж байгаа бас хэлэлцээд энэ хувийн эрх зүйн болоод нийгмийн суурь асуудлуудаа бас нэг зөв ойлголттой явах ёстой. Тэгээд бид ер нь нэр томьёог ч гэсэн сонгож хэрэглэхдээ буруу явсаар байгаад энд хэцүү болчихоод байгаа юм. Жишээ нь гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нэр томьёог бас буруу л хэрэглэчихсэн юм анхнаасаа. Уг нь амьдрах орчны хүчирхийлэл байхгүй юу. Энд нь гэр бүлийн хүчирхийлэл гэхээр гэр бүлтэй яг дүйцүүлж авч үзэх, адилтган амьдрах орчинд үзчихдэг, сургуулийн орчин дахь хүчирхийлэл орчихдог дотуур байрны шүү.

Дээрээс нь СЭМТ дээр байгаа хүчирхийлэл хүртэл ордог байхгүй юу гэр бүлийн хүчирхийлэлд. Тэгэхээр энэ анхнаасаа ингээд бас нэр томьёо энэ тэрийг бас зөвтгөх, энэ шинжлэх ухааны үндэстэйгээр нэр томьёогоо бас бодож хэрэглэх асуудал байсан юм. Ер нь нэгэнт Гэр бүлийн хууль ярьж байгаа учраас энд холбоотой нэр томьёонуудыг ч гэсэн цаашдаа судлан шинжлэх. Уг нь амьдрах орчны хүчирхийлэл гээд явбал илүү яг бодитой бөгөөд цаад талын үр дагаврууд ч гэсэн их цэгцтэй харагдах л байсан юм шиг байгаа юм.

Би яах вэ энэ яг хуультай тухайлан санал бол дагаж мөрдөх журмын зохицуулалт дээр энэ ургийн овгийг шинэчлэх ажлыг иргэдэд нэг боломжийг нь олгохгооч. Ядаж энэ Боржигон овгийг авч байгаа хүмүүс чинь бичилт нь янз янзаараа байгаа байхгүй юу. Боржигон дээр ч биш ер нь яах вэ би өөрийнхөө л ойр тойрны хүмүүсийг харахаар “Э” үсгээр, “И” үсгээр бичээд дуудлагаараа биччихсэн ингээд зөрдөг, яг хамаатан садан нь мөн биш нь мэдэгддэггүй ийм зүйлүүд байгаа юм. Энийг нэг удаадаа өөрсдөө иргэний үнэмлэхээ солиулах явцдаа иргэд өөрсдөө сонголтоороо баталгаажуулаад нэг удаа ургийн овгоо солих асуудлыг яг энэ дээр хийж өгье.

Зарим оронд ингээд утасны аппликэйшн хийчихсэн байдаг юм. Нордик орнууд дээр. Ялангуяа зэрэгцээд ч юм уу сууж байгаа 2 хүн тэр аппликэйшнээрээ 2 утсаа ингээд тулгахад та 2 тэддүгээр үеийн хамаатнууд байж болзошгүй гэж гарч ирдэг байхгүй юу. Тэгэхээр ер нь энэ жишээ нь Финлянд байгаа. Финляндын загварыг бас аваад үз, судалчих хэрэгтэй. Хүн ам багатай. Энэ хүн ам зүйн бодлого буюу энэ цус ойртолтоос ингээд урьдчилан сэргийлэх бодлогоо бас ийм аппликэйшн буюу технологи ашиглаад хийчихсэн байхгүй юу. Тэгэхээр ийм зүйлүүдийг байна.

Тэр ДНХ-ийн шинжилгээ энэ тэр өнөө, маргаашдаа бас хэцүү. Тийм учраас бид хэд энэ ургийн овгийг бас цэгцлэх асуудлыг энэ Гэр бүлийн хуулийн хэлэлцэж байгаадаа шийдье.

Хамтын амьдрал буюу тэр 21 дүгээр зүйл дээр байна л даа. Ер нь гэр бүлийн харилцаатай дүйцүүлж үзэх нэг асуудал ороод ирж байгаа юм. Энэ гэрэлтэй адилтгах харилцаа. Тэгээд 5 жил хугацаа тавьчихаад байгаа байхгүй юу. Гэрэлт гэдэг чинь 1 хоногийн дараа ч адилтгаж үзэж болно. Зарим 5 жил дотор чинь бараг 3, 4 хүүхэд ч төрүүлчихэж болно шүү дээ.

Яагаад ийм харилцааг аваачаад хугацаагаар боогоод тэрний үр дагаврыг 5 жилийн хугацаагаас боож байж үр дагавар нь шийднэ гэж оруулж ирж байгаа юм?

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Энэ чинь буруу байхгүй юу. Тэгэхээр энэ чинь тодорхой суурь нөхцөлүүд байна. Эргээд энэ дээр оруулбал хүүхэдтэй нөхцөл байдлуудыг л хэдүүлээ бодохгүй бол энэ ерөөсөө хугацаа зааж орж ирж байгаа. Дээрээс нь энэ чинь гэр бүл яг албан ёсны гэр бүл болохоос ер нь түдгэлзүүлэх ийм нөхцөлүүд байгаа шүү дээ. Болчихно, ийм сэдэл болчихно. Тэгэхээр энэ дээр бас ажлын хэсэг гарахдаа анхааръя.

Энэнтэй зэрэгцээд тэр Гэр бүлийн хөгжлийг дэмжих хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах хуулиудтай холбоотой өөрчлөлтүүдийг яаралтай оруулж ирээрэй. Энд орж байгаа бүх зохицуулалт чинь дандаа үр дагавар нь төр талаасаа болон орон нутаг талаасаа эсвэл тодорхой хэмжээний механизм шаардсан, санхүүжилт шаардсан ийм зүйлүүд байна шүү. Энийг зэрэгцүүлж авч явахгүй бол энэ хууль чинь хэрэгжихгүй. Маш их хэмжээний нийгэмд үл ойлголцлууд үүснэ. Тийм учраас Засгийн газар талаасаа энэ хуулиудаа уялдуулж орж ирэх талаасаа анхаараач. Яагаад гэхээр 4 сарын 1-нээс гээд тавьчихаж. Шүүх бол хэрэглээд л эхэлнэ. Тэгээд энэ чинь дараа нь үр дагаврыг нь хэн хариуцах вэ гэдэг асуудал байгаа.

Нэг хамгийн юм байгаа. Эрх зүйн чадамжгүй буюу бүтэн өнчин энэ хүүхдүүдийн асрамж халамжид байхдаа тэдгээр хүүхдүүдийн эд хөрөнгийн эрх маш ихээр зөрчигдөж байгаа. Насанд хүрсэн ч гэсэн эрх зүйн чадамжгүй гэж тогтоож байгаад ах, дүү, амраг саднууд нь янз бүрийн байр сав, эд хөрөнгийг нь зарцуулдаг юм. Тэгээд нэг хүмүүс чинь бас яг ингээд явъя гэхээр бас юмаа ойлгоод байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ дээр хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй өгдөг яг ийм эд хөрөнгийн эрхтэй маргаан гарвал төр өөрөө бас оролцох энэ нөхцөл байдлуудыг энэ дээр илүү хийж өгөх ёстой юм. Энэ маш олон жишээнүүдийг би мэднэ. Би Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажиллаж байхдаа энэ чиглэлийн маш олон хүмүүстэй уулзаж байсан байдаг юм. Тэгээд энэ Гэр бүлийн хуулийг ямар ч байсан дэмжээд явъя.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Юуны өмнө би ажлын хэсэгт орох хүсэлтэй байгаагаа Байнгын хорооны даргад үүгээр уламжилъя.

Хоёрдугаарт бас яг энэ Гэр бүлийн тухай хуультай иргэд, олон нийт, байгууллагуудаас ирсэн саналын ТОВЬЁГ-ийг авмаар байна. Бид нарт и-мэйлээр ирсэн материал дотор ирээгүй байсан. Тэрийг бас тусгайлан авъя. Бас гишүүдэд ч гэсэн хүргүүлэх нь зөв байх гэж бодож байна.

Гуравдугаарт гэвэл яг энэ НҮБ-аас ирүүлсэн хэд хэдэн удаагийн зөвлөмжүүд дотор энэ хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл, нийгмийн амьдралд оролцох эрхийн асуудал дээр үүсэж байгаа хязгаарлалтууд дээр нэлээн эргэж харах ийм байр суурьтай байгаа. Тэгээд энэ дээр бас холбогдох ажлын хэсэг, яамныхан бас энэ дээр анхаарах ёстой байх гэж бодож байна.

Гуравдугаарт, ялт ч үгүй манай үндэсний дотоодын онцлог байгаа. Сая Мягмар даргын хувьд энэ асуудлыг Боловсролын яамны хариуцах асуудал гээд дотуур байрны хүүхдийн асуудлыг хэлж байх шиг байна. Боловсролын яам нь болохоор энэ бол Гэр бүлийн яам гэр бүлийн асран хамгааллын асуудалтай холбоотой болохоос биш манай яамны асуудал биш л гэдэг байхгүй юу. Гэтэл манай Монгол Улс шиг ингэж өвлийн энэ урт хоног, саруудад энэ олон хоног

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүүхдээ өөрсдийнхөө асрамж, халамж, хараа хяналтаас хол байлгадаг ийм боловсролын тогтолцоотой орон ер нь байхгүй. Африкийн хэдэн орнууд л дотуур байрны асуудал байдаг. Манайх шиг яг ийм бүх сургууль, ЕБС нь тэр чигээрээ ийм дотуур байран дээр суурилдаг ийм тогтолцоотой орон байхгүй байхгүй юу.

Тэгэхээр бид нар өөр улс орноос хуулбарлах гээд ч хуулбарлах юм байхгүй. Гэтэл яг дотуур байрны хүүхэд дээр үүсэж байгаа олон асуудлууд үүсдэг. Асран хамгаалалтын холбоотой асуудлууд байнга үүсдэг. Тэр хүүхэд хэрэгт холбогдоно, гэмт хэргийн хохирогч болно. Тэр тохиолдолд багш нь байх юм уу, эцэг, эх нь байх юм уу, тэр хүүхдийн асран хамгаалал нь яах юм гээд байнга энэ маргаантай явж ирсэн. Тэгээд ялт ч үгүй Гэр бүлийн тухай хуулиараа гэр бүлд нь л очдог. Гэтэл эцэг, эхээсээ ялт ч үгүй хол байгаад байдаг. Тийм учраас НҮБ-аас тэр зөвлөмжийг өгөөд байгаа байхгүй юу.

24 цагаас дээш хугацаанд хүүхэд эцэг эхийнхээ асрамжаас хол бол тэр асран хамгааллыг эсвэл асран хамгаалалт хувилбарт үйлчилгээ гэж байдаг. Хувилбарт үйлчилгээ гэдэг ангилал руу эсвэл бид нар оруулах хэрэгтэй болж таарна гэх мэтээр ингээд бид нар жоохон ингээд өргөн цар хүрээтэй харах хэрэгтэй байгаа.

Эцэст нь бас нэг зүйлийг би хэлмээр байгаа. Ялангуяа гэр бүлийн олон янз байдал дээр гарч байгаа өөрчлөлтийг бид нар жоохон энэ хуулийнхаа концепцоороо бас бид нар оруулж ирж харах ёстой юмнууд байгаа байх. Яг гэр бүлийн уламжлалт ойлголт, хандлагаас гадна өөр бусад гэр бүлийн ойлголтуудыг, олон янз байдлуудыг хүлээн зөвшөөрөх, түүнийг нь бид нар яг энэ хуулийн хүрээнд гэр бүл гэдэг энэ ангилал руугаа оруулах энэ тэр гээд ингээд олон зүйлүүдийг бид нар эргэж харах хэрэгтэй болно. Нийгмийн амьдрал юм чинь өөрөө асар их хөгжлийн хүрээнд явж байгаа.

Хуулийн давхардал, хийдлийн асуудлууд бас байна. Ялангуяа бас энэ сүүлийн үед бас энэ бэлгийн цөөнхийн асуудал, энэ гэр бүлийн асуудал яригдаад байгаа. Нэгэнт Үндсэн хуулиараа гэр бүл болох боломжгүй байгаа. Энэ дээр бас заавал Гэр бүлийн тухай хууль дээр дахиж ийм заалт бас оруулж ирэх яг ямар хэрэгцээ, шаардлага байгаа юм гэдэг бас ийм асуулттай үлдэж байгаа.

Хамгийн сүүлд би асуусан гэр бүлийн бусад хууль тогтоомжуудынхаа уялдаануудыг хэдүүлээ хараад уг нь ингэж цогцоороо явдаг бол мэдээж хэрэгтэй байна. Гэхдээ нэгэнт бусад хууль тогтоомжууд нь өргөн баригдаагүй байгаа учраас бас энийг бас хэдүүлээ яаж харах вэ гэдэг дээр ажлын хэсэг бас дотроо энийг ярилцах хэрэгтэй байх. Тэгээд Иргэний нийгэм, ТББ-ын оролцоо, нэгэнт төр өөрөө бүх энэ гэр бүлийн асуудалтай холбоотой бүх асуудлыг хариуцаж авч явахад бэрхшээлтэй учраас тодорхой хэмжээгээр ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа дээр Иргэний нийгэм, ТББ-ын оролцоог яаж оруулж ирэх вэ, яаж хамтрах вэ гээд ингээд иргэний оролцоог бас бид нар нөгөө талаас нь бас харах ёстой байх гэдэг ийм байр суурьтай байна. Тэгээд ажлын хэсэгт орох хүсэлтэй байгааг илэрхийлье.

Д.Цогтбаатар: Би цөөхөн хэдэн үг хэлнэ. Энэ дээр нэгдүгээрт хуулийн төслийг дэмжиж байгаа. Мэдээж 99 онд батлагдсанаас хойш амьдрал урагшилчихсан. Монголын нийгэм энэ ардчилсан зах зээлийн тогтолцоо системдээ шилжээд өөрөө жигдрээд явж байхад энд өмнөх харилцааг зохицуулж байсан

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хуулиуд мэдээж гүйцэхгүй энэ ард хоцорч байгаа юмнууд нэлээн бий. Энэ дээр би хэд хэдэн зүйлийг гэхдээ ажлын хэсэгт манай Байнгын хорооны гишүүд идэвхтэй саналаараа ороод ажиллаарай. Яагаад гэвэл энэ үнэхээр суурь хууль гарах гэж байгаа. Тэгэхлээр энэ дээр би бас дараагийн энэ ажлын хэсэг ч гэсэн нэгэнт Их Хуралд орж ирж байгаа юм чинь Их Хурал дээрээ нэлээн юмнуудаа гүйцээгээд, боловсруулаад явах ёстой. Тэгэхлээр энэ дээр юмыг бас анхаарах ёстой. Энэ маш чухал хууль гэж ярьж байгаад зохицуулах шаардлагагүй бөгөөд зохицуулах боломжгүй юмнуудыг зохицуулах гээд явах вий дээ. Ийм юм руу орчих юм бол наадах чинь эргээд гэр бүлдээ гэр бүлийг аврах тухай асуудал энд яригдаад байдаг, гэр бүлийг эрх зүйн хүрээнд нь харин хүндрүүлэх ийм нөхцөл байдлуудыг бий болгочих вий дээ.

Тэгэхлээр энэ юмнуудаа нэлээн анхаарч, бодож тал талдаа ажиллаарай. Би түрүүн тэр ДНХ-ийн юун дээр жишээлбэл болно гээд л ингээд заачихсан байгаа. Тэртээ тэргүй хүмүүс өөрөө эрүүлээр сэтгээд тэрийг хийх юмыг энд тэртээ тэргүй эрх зүйн ямар нэгэн норм тавилгүйгээр ингээд болно гээд тавьчихсан байгаа бол тэртээ тэргүй өнөөдөр тэрийг чинь хүмүүс хийлгээд л явж байгаа. Тэрийг хаачихсан юм байхгүй байгаа шүү дээ. Манай гишүүд энэ дээр харин нэг юмыг бид нар бодож ажиллах ёстой. Ялангуяа ажлын хэсэг. Өнөөдрийн энэ харилцаа тэртээ тэргүй өдий болтол зохицуулагдаад явж байгаа учраас энэ хуультай, хуульгүй энэ харилцаа маань бас зохицуулагдаад л явж байгаа.

Гэхдээ бид нар холбогдох шүүхийг нь байгуулаад, Гэр бүл, хүүхдийн шүүхийг байгуулаад 1 сарын 1-нээс, 25 оны 1 сарын 1-нээс гээд энэ чинь уг нь 25 оны 6 сард байх аа хэрэгжих ёстой байтал энийгээ бид нар хойшлуулаад 25 оны 1 сар болгон хойшлуулчихсан байгаа. 24 оны 6 сард байсан шиг санаж байна. Тэгтэл одоо ингээд хойшлуулчихсан явж байгаа. Тэгэхлээр энийг ингээд хойшлуулаад ахиж хойшлуулалгүйгээр ажил хэрэг болгохын төлөө бид нар илүү хурдацтай л ажиллах ёстой. Тийм учраас энэ Их Хурал дээр байгуулагдах ажлын хэсэг энэ дээрээ анхаарч идэвхтэй ажиллаасай л гэж хүсэж байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, энэнтэй холбогдсон дэмжсэн, дэмжээгүй саналаа хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье..

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73 хувиар санал дэмжигдлээ.

5.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73.3 хувиар санал дэмжигдлээ.

6.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73.3 хувиар санал дэмжигдлээ.

8.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

10.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73.3 хувиар санал дэмжигдлээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Цогтбаатар гишүүн танилцуулчих уу? Даваагийн Цогтбаатар гишүүн танилцуулна.

Гишүүн ээ яана шүү дараагийн асуудалдаа оръё. Ахиад асуудал байгаа шүү дээ. Бас санал хураана. Тийм одоо хураана. Одоо яг энэ хуулийн чинь процессын хууль орж ирж байгаа байхгүй юу.

13.31 цаг

Хоёрдугаар асуудал. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төсөл.

Засгийн газар 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт танилцуулна. Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн Давж заалдах шатын шүүх, 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.

Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Түүнчлэн “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-д нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн болон давж заалдах шатын шүүх байгуулсантай холбогдуулан Эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан болно.

Үүний дагуу Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр танилцуулж байна.

Олон улсын туршлагаас үзвэл 1949 онд Япон улсад байгуулагдсан Гэр бүлийн хэргийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны гэр бүлийн хэргийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан бөгөөд Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх хуулиар гэр бүлийн хэрэгт тохирсон онцлог, процесс ажиллагааг нь зохицуулдаг байна. Түүнчлэн БНСУ 1963 онд Сөүл хотын гэр бүлийн хэргийн

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дагнасан шүүх байгуулагдсан нь Япон улсын дараа орох анхны гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь гэр бүлийн хэргийг дагнан, хянан шийдвэрлэх бие даасан хуулиар гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон байдаг.

Иймд Монгол Улс анх удаа Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүхтэй болж байгаа тул олон улсад нэгэнт тогтсон гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэдэг сайн туршлагыг судлан хүүхдийн тэргүүн дээд эрх ашиг, сонирхлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамгаалах зорилгоор олон улсын жишигт нийцүүлэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг 5 бүлэг 40 зүйлтэйгээр боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх нь хэргийг шийдвэрлэхдээ тухайн гэр бүлийн нөхцөл байдлыг бүрэн, тал бүрээс нь шинжлэн судлах, нэг шүүхэд гэр бүлийн холбогдолтой тухайлбал, гэрлэлт цуцлалт, гэр бүлийн хүчирхийллийн хэргийг хамтад нь шийдвэрлэх, хүүхдийн эрхийг хамгаалахыг зорилго болгон ажиллах болно.

Хуулийн төслийг дагалдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай зэрэг 12 хууль тогтоомжийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Бямбацогт сайдад баярлалаа. Одоо хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Түрүүн хэвээрээ. Түрүүн уншаад ер нь танилцуулчихсан. Гэхдээ уншаад танилцуулчихсан хүмүүсээ би орхичихъя тэгэх үү? Энэ бүх хүмүүс бүгдээрээ байж байгаа юм чинь. Энэ дээр Улсын дээд шүүхийн Иргэний танхимын шүүгч Алтанчимэг шүүгч байна. Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч Батцэрэн шүүгч байна. Энэ 2 түрүүн уншигдаагүй өнгөрчихсөн байж байгаа. Бусад нь уншаад танилцуулчихсан байж байгаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Ямар ч байсан Гэр бүлийн хууль материаллаг хуулиа дагаад бас Гэр бүл, хүүхдийн шүүх байгуулахтай холбоотойгоор бас ингээд бие даасан процессын хууль орж ирж байна. Яах вэ энэ процессын хууль бие даасан хуультай байж болно. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа тухайлан бүлэг оруулаад явах ч ийм хувилбар байсан байх. Бие даасан хуулиар нь орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр ер нь шүүхийн шийдвэрийг шүүхийн энэ процессын үйл ажиллагаа хэрэг маргааныг үүсгэхээсээ эхлээд энэ гарсан шийдвэрийн биелэлтийг хангах хүртэл холбоотой энэ харилцааг л бид нар иж бүрнээр нь харах ёстой байгаад

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа юм. Тэгээд энэ хууль дээрээ уг нь яг энэ гэр бүлтэй холбоотой шүүхээс гарч байгаа шийдвэр, гүйцэтгэлийн асуудлыг ер нь хэрхэн, яаж шийдвэрлэж байгаа вэ? Болж өгвөл уг нь энийг нэгмөсөн шүүх эрх мэдлийн байгууллагад нь яг энэ хэсгийг ингээд өгч болохгүй байсан уу? Энэ дээр бид хэд бас жоохон өөрчлөлтүүд хийхгүй бол энэ дандаа хаягддаг. Хүүхдийн тэтгэмж гаргахаас эхлээд сая бид нэлээн зөрчлийн хэрэг үүсгэх нь гэж байж бас төлөлтүүд ингээд явж байгаа жишээний юмнууд байгаа. Тэгэхээр энэ шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр ямар бодлогын өөрчлөлтүүд бас орж ирж байгаа вэ? Хуучин тогтолцоогоор орж ирж байна уу, эсвэл бас өөрөөр харах шаардлага зүй ёсоор байна уу үгүй юү?

Би энэ шүүхээс жоохон эхлээд хандлагаа өөрчлөөсэй гэж бодож байгаа. Манай шүүгч нарын туслахуудыг заавал эрх зүйч байхыг шаарддаг. Магадгүй хуульчаар ажилласнаар тооцдог ч байж болно. Ер нь гэр бүлийн шүүх, арилжааны шүүхүүд дээр санхүүч ч байдаг юм уу өөр чиглэлийн хүмүүст туслахаар ажиллах бололцоог нээж өгөх ёстой. Ялангуяа сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, магадгүй би дүйцүүлээд дайраад явах юм бол ингээд “market court”-ууд буюу арилжааны шүүхүүд дээр жишээ нь санхүүгийн, эдийн засгийн мэргэжилтэй хүмүүс яг шүүгчийн туслах хийх нь илүү оновчтой байдаг байхгүй юу. Яг үүнтэй адилхан Гэр бүлийн шүүх дээр зөвхөн эрх зүйчээр гэхгүйгээр энэ туслахуудын асуудал дээр тэр шүүгч шүүн таслах ажиллагааг буюу яг энэ онцлогтой хэрэг маргааныг шийдэхэд бас мэргэжлийн ур чадвар шаардагдана. Энэ дээр туслах тийм гэр бүлийн сэтгэл зүйч ийм чиглэлийн хүмүүсийг бас ажиллуулах энэ байдал дээр бүтцийг бас анхаарах хэрэгтэй байгаа юм. Энэ дээр ямар бодол шүүхийн хууль дээр өөрчлөлт орох дагаж байгаа юм байгаа гэдэг асуудал байна.

Хоёрдугаарт, өөрт нь шүүгч нарт тавигддаг шаардлагууд байдаг бусад орнуудад. Ялангуяа энэ гэр бүлийн шүүх дээр ажиллах гэж байгаа шүүгч өөрөө гэрлэсэн байхыг шаарддаг. Гэрлэсэн дундаа хүүхэдтэй байхыг шаарддаг ийм орнууд бас байна. Тэгэхээр бид хэд бас тухайлан энэ шүүгч болж энэ шүүх дээр ажиллах хүмүүс дээр ийм шаардлагууд тавьж байгаа юу? Прокурор бас дагаад гэр бүлийн хэрэг маргаантай холбоотой энэ асуудлыг авч шийддэг тухайлан нэгж байгуулах асуудал байгаа юу үгүй юү? Энэ асуудал дээр бас яриач гэж хүсэж байгаа юм. Ингээд дагаж байгаа хуулиуд дээр маш их хэмжээний бас эрх хязгаарлах, таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг шиг юмнууд байна. Сургалтад суух, гэртээ байх ч гэдэг юм уу. Ер нь энэ хууль.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Тэгье. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энэ хуулиудыг дагаад түрүүн Бааска гишүүн бид хоёрын хэлээд байгаа тэр Гэр бүлийн хөгжлийг дэмжих хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах хуулиудаа оруулж ирээрэй. Ялангуяа уг нь гэр бүлийн хөгжлийг дэмжих асуудал бол энэ “community center” байгаа. Хүн болгон заавал суралцаад сургалтад сууснаар бүх юм дуусчихгүй. Гэр бүлд наад захын хоол ундны илчлэгээс эхлээд эхнэр, нөхөрт асуух зүйл байдаг. Бусад оронд “community center”-ээсээ ороод л мэдээлэлтэй танилцчихдаг байхгүй юу. Эргээд үр хүүхдээ яаж вакцинд хамруулахаас эхлээд л асуучихдаг. Бид хэдийн мэдээлэл өгөх энэ суваг гэдэг юм уу бас төрд байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр ийм зүйлүүдийг бас илүү цаашдаа бас анхаараарай гэдэг зүйл байгаа. Тэгээд яах вэ энэ шүүхийн харьяалалд нь шийдэх хэрэг дээр бас тодорхой хэргүүдийг заагаад онцгой ажиллагааны журмаар шийдэх хэргүүд байна. Тэгэхээр энэ эрх зүйн ач

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

холбогдолтой үйл явдалд ялангуяа энэ овог, нэр тогтоолгох энэ асуудал энэ тэрийг бас тодорхой оруулж өгөөрэй гэдэг зүйл байгаа.

Эрх зүйн ч чадамжгүйд тооцох энэ асуудлыг харин нэлээн сайн процессжуулж өгмөөр байна. Тэнд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд асуучих асуучих. Хариулт хэн өгөх вэ? 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрхлэлттэй холбоотой асуудлыг яг энэ хуулийн зохицуулалтаар шууд тусгаж оруулж ирээгүй. Мэдээж Гэр бүлийн хэрэг дагнасан шүүхтэй холбоотойгоор гарч байгаа шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн асуудлыг ялангуяа жишээ нь хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой гэдэг юм уу энэний гүйцэтгэл энэ тэрийг хариуцахтай холбоотой зүйлүүдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх багц хуулийн төслийг өнгөрсөн хавар өргөн мэдүүлсэн байж байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл дээр тусгасан зохицуулалтаар төсөөлж ингэж хэлэлцэх эсэх нь шийдэгдээд явчихвал энэ зохицуулалтаараа явна гэдэг энэ ойлголтоор явж байгаа.

Шүүхийн таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой, хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон зохицуулалтуудыг Эрүүгийн хэгэг хянан шийдвэрлэх тухай хууль энэ тэр дээр бол Эрүүгийн хууль дагасан хуулиуд дээр нь тодорхой зохицуулалтуудыг оруулж ирсэн байж байгаа. Тэгээд энэ шүүгчийн туслахтай холбоотой асуудал, шүүгчид тавих асуудал, шүүгчид тавигдах шаардлагатай холбоотой асуудал дээр манай Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хариулна гэж ингэж ойлгож байна.

Гэр бүлийн энэ дагнасан шүүх дээр саяын таны ярьдгаар бусад мэргэжлийн хүмүүс оролцох энэ боломж нь тухайлбал гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч гэдэг энэ шүүхийн бүтцэд ажиллахаар ингэж оруулж ирж байгаа. Энэ хүн маань социологич, боловсролын болон сэтгэл зүйн ийм мэргэжилтэй ийм хүн байхаар энэ тэр гээд зааж ирж байгаа. Мөн эвлэрүүлэн зуучлалын шүүх дээрх баг дээр эвлэрүүлэн зуучлалын тэр орон тооны бус зуучлагчийн энэ тэр тавигдах шаардлагууд энэ тэр орж ирж байгаа. Тэгэхлээр энэ бусад энэ шүүгчийн туслахын онцлог нь шүүгчид тавигдах шаардлагатай холбоотой зүйл дээр манай Шүүхийн ерөнхий зөвлөлөөс мэдээлэл өгөхийг хүсье. Тэгээд бусад таны хэлж байгаа бусад хуулиудыг дагалдуулж оруулж ирэх шинэчлэлийн асуудал дээр Хууль зүй, дотоод хэргийн яам энэ дээр анхааръя.

Д.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хэн хариулах вэ? Хэддүгээр микрофон? 3. Мягмар даргын яг хажуугийн юун дээр та суучих. 3 дугаар микрофон өгье.

П.Золзаяа: Би товчхон хариулъя. Ер нь гэр бүлийн шүүхэд ажиллах шүүгч мэргэшсэн байх ёстой. Ажиллаж байгаа шүүгч нар илүү туршлагатай. Тэгэхдээ яг энэ чиглэлээр бас мэргэшүүлэх шаардлагатай гэж бид нар эхнээсээ тийм зорилго тавьсан. Энэ үүднээс гэр бүлийн шүүхэд шүүгчийг сонгон шалгаруулах энэ шалгалт явж байгаа. Тийм ч учраас бас энэ шалгалтыг нэлээн нарийн мэргэшсэн чиглэлээр авсан. Тэнцэж байгаа хүн нь жишээлбэл анхан шатын шүүхэд гэхэд 180 хүнээс 3 хүн тэнцсэн. Одоо давж заалдах шатын шүүхийн сонгон шалгаруулалт явж байгаа ийм байдалтай байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нар анхаарч байна. Туслах бол заавал хуульч байх албагүй гэдэг дээр үнэхээр санал нэг байна. Яг энэ талаар яг энэ хуульд оруулаад тусгачихсан ийм зүйл байхгүй. Энийг анхаараад бас цаашид яах боломжтой гэж харж байна. Өөр чинь юу билээ.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд микрофон өгье. Тодруулъя.

П.Сайнзориг: Баярлалаа. Хэдүүлээ нэг явж ирсэн юмнууд дээр жоохон жоохон бас эвдээд харах юмнууд байгаа. Би ялангуяа энэ хэрэг маргааны хувьд онцлогтой юман дээр социологич нар ч байдаг юм уу илүү их сэтгэл судлаач нар шүүгч нартай туслахаар нь ажиллаж өгвөл бас илүү их сайн байх. Магадгүй яг өөрийнх нь шууд туслах биш ч гэсэн шүүгч дундын туслахууд бас байж болно тээ? Тэгэхээр энэ хувилбар руу бас юмнуудаа бодъё.

Хоёрдугаарт энэ дагаж байгаа хууль дээр миний нэг хараад байгаа юм Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль орж ирээгүй. Энэтэй холбоотой бас энэ эрх зүйн маргаануудын Гэр бүлийн шүүхэд өгч байгаа маргаанууд дээр Захиргааны шүүхэд харьяалагддаг маргаануудын хооронд бас давхцалууд бас байгаад байгаа. Энийг уг нь тэр асуудлаас нь үзэх байсан юм даа. Ялангуяа тэр гэрлэлтийн гэрээг Улсын бүртгэлд бүртгүүлэх энэ чиглэлийн юмнууд энийг чинь тодруулж өгөхгүй л бол субъектийн хувьд төрийн байгууллага оролцож байгаа гэдгээр захиргааны шүүх татаж авдаг хандлага ер нь байгаад байгаа. Энийгээ мэдээж засаад байгаа боловч уг нь энэ дээр илүү их тодруулаад оруулаад өгчих ёстой байсан юмнууд байна.

Хоёрдугаарт энэ дагаж байгаа хууль дээр бас юм байгаа. Энэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн микрофондоо хэлчих. Энэ архивд үлдэх ёстой. Сайнзориг гишүүний микрофоныг өгчихье.

П.Сайнзориг: Баярлалаа дарга. Би бас чухал гэж бодоод л асуугаад байгаа юм шүү. Энэ өсвөр насны яллагдагч шүүгчдэд бас яах вэ таслан сэргийлэх арга хэмжээний төрөл дээр батлан даагчийн хяналтад өгөх гээд байгаа юм. Заавал хоёроос доошгүй гэж байгаа юм. Нэг хүн байж болно. Ганц бие аав, ээжүүдэд заавал ийм хүндрэл учруулаад хамаатны хүнээ олж ирэх энэ тэр гээд. Юмыг хийхээрээ ийм яг иргэдэд жоохон төвөгтэй байдлаар хийх юм.

Хоёрдугаарт энэ дээрээ ингээд тэр хүүхдийг батлан даалтад авсан хүнд ингээд ял халдаан хэрэглэх гэж байгаа байхгүй юу Зөрчлийн хуулиар хариуцлага тооцно гээд. Хэдүүлээ жоохон энэ зүйлүүдээрээ өөрчилж бас энийг орж ирэх ёстой шүү. Би ер нь хэлэх гэж байгаа тайлбарыг мэдэж байна. Тэгэхдээ энэ өөрөө эргээд бусдын өмнөөс энэ хариуцлага хүлээдэг ийм зүйл байхгүй. Аль болохоор энийг жоохон уялдуулж авч үзэх ёстой байгаа. Тэр Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээнэ гэж юм байхгүй. Харин эрэн сурвалжлаад олох тэр зардлыг гаргуулж болно. Ингэж хэдүүлээ юмыг жоохон халдааж хэрэглэдэг энэ зүйлүүдээ, хандлагаа өөрчлөхгүй бол ингээд л яг л өмнө нь яригдаж байсан юмнуудыг ингээд л заримдаа ингээд.../минут дуусав./

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ ажлын хэсгээс? 3 дугаар микрофон Батцэрэн шүүгч.

Б.Батцэрэн: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Гэмт хэрэгт холбогдсон хүнийг мөрдөн шалгах явцад хэд хэдэн төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авдаг. Насанд хүрсэн хүний хувьд ийм батлан даалтад өгөх гэдэг ийм таслан сэргийлэх арга хэмжээний төрөл байхгүй. Тэгэхлээр хүүхдийн хувьд тусгайлан ийм нэмэлтээр батлан даалтад өгөх ийм таслан сэргийлэх арга хэмжээний хэлбэрийг шинээр хуульд оруулахаар төсөлд тусгасан байна.

Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцэх явцад заавал хоёроос доошгүй хүн байх шаардлага бий юү, нэг хүн байж болохгүй юу гэдгийг хэлэлцүүлгийн явцад шийдвэрлэх бүрэн боломжтой гэж бодож байна. Хариуцлагын хувьд ер нь 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ бол байсан.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Б.Батцэрэн: Батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээний зохицуулалт нь 2002 оны хуулийн зохицуулалттай ер нь агуулгын хувьд ижил байгаа. Батлан дааж авсан өсвөр насны хүн оргон зайлуулбал эрэн сурвалжлахтай холбоотой зардлыг нөхөн төлүүлэхийг үүрэг болгож байна. Урьдчилан энэ талаар сануулна. Дээр нь энэ үүргээ зөрчвөл хүлээлгэх хариуцлагын асуудал байх ёстой гэдгийг мөн энэ хуулийн төслийг хэлэлцэх явцад бас шийдвэрлэх боломжтой гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Хуулийн төсөлтэй танилцсан. Хэд хэдэн асуулт байна. Төсвийн үед ч гэсэн би асууж байсан. Яг энэ хүүхэд, гэр бүлийн шүүх байгуулахад бэлэн юм уу, маш их зардал урьдчилж бэлтгэл хангах хэрэгтэй гэж уг нь харж байгаа гээд. Тэгээд харамсалтай нь тухайн үед зөвхөн түрээсийн байрны тухай л яриад өнгөрсөн. Одоо тэгээд зөөлөн бодлого буюу яг хүний нөөцөө бэлтгэх, хүүхэд, гэр бүлийн агентлагтай хамтарч ажиллах, мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажиллах гээд энэ тал дээр яг хийгдэж байгаа ажил яг бэлэн байдал хэр байгаа вэ? Энэ дээр манай Хууль зүйн байнгын хороо ч гэсэн энэ дээр анхаарах ёстой гэж би хувьдаа харж байгаа юм. Одоо төсвийг нь батлаад өгчихсөн.Одоо бид нарт хамаагүй гэж бид нар байх ёсгүй гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр бас манай Хууль зүйн байнгын хороо ер нь жаахан манлайлал гаргаасай гэж хүсэж байгаа шүү гэдгийг бас ташрамд нь даргадаа хэлчихье.

Хоёрдугаарт, эвлэрүүлэн зуучлалын асуудал энэ хууль хоёр хоорондоо аягүй уялдаатай байх ёстой гэж харж байгаа байхгүй юу. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль гээд. Гэтэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль дээр маань бас аягүй олон асуудлууд байгаад байгаа. Тэгээд энэ уялдааг бодлогын хувьд цаашаа яая гэж харж байгаа вэ гэдэг дээр хариулт авмаар байна.

Гуравдугаарт, Улсын дээд шүүх хэд хэдэн журам батлахаар хуулийн төсөлд орж иржээ. Энэ ер нь болж байгаа юу? Ялангуяа тэр үнэлгээ, шинжилгээ хийх журмыг Улсын дээд шүүх батална гэж байна. Тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална гэж байна. Тэгэхээр ингээд яг ийм процессын шинжтэй хэм хэмжээг

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Улсын дээд шүүх тогтоох боломж хэр байгаа вэ? Энэ яагаад яам биш Улсын дээд шүүх гэж орж ирсэн юм гээд?

Энэ шүүхийн ажилтан шинжээч гээд дахиад Шинжилгээний тухай хууль энэ шүүхийн ажилтан шинжээчид хамаарахгүй гэж ойлголоо тээ хуулийг харвал. Гэтэл яг шинжээч гэдэг нэр томъёог чинь давхар хэрэглээд яваад байна. Дахиад хуулийн нэр томъёо, янз бүрийн кодификацын асуудал, дээрээс нь хууль хэрэглээний хувьд асуудал үүсэх бий дээ л гэж би жаахан болгоомжлоод байна. Ялангуяа энэ ажилтны гаргасан дүгнэлтэд гомдол гаргах эрхгүй гээд, энэ хүнийг томилсон шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй гээд маш их гомдол гаргах эрхийг хэд хэдэн газар нэлээн хэдэн газар хязгаарлалчихсан л байгаад байна л даа. Мэдээж процессыг хурдан хийх гэж байгааг ойлгож байгаа. Гэхдээ бас яг энэ процессын явцад гомдол гаргах эрхийг бас ингэж хязгаарлах нь хэр оновчтой вэ? Үүний цаад шалтгаан нь юм бол гэдэг ийм асуулт байна.

Хамгийн сүүлийн асуулт яг энэ процессын хуулиас гадна нэг асуултыг асуумаар байгаа юм. Яагаад гэвэл хүүхдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа ялангуяа хорих ял оногдуулж байгаа гэмт хэргийн төрлийг бууруулах тал дээр ямар бодлого байгаа вэ? Яваандаа энэ шүүх өөрөө угаасаа хүүхэдтэй холбоотой хэрэг маргааныг ч гэсэн эрүүгийн хэргийг, зөрчлийн хэргийг шийдвэрлэнэ.

Гэтэл цаад хорих ял гэдэг юмыг ерөөсөө энэ хүүхдээс бүүр болимоор байгаа байхгүй юу. Бид нар концепцын хувьд энэ өөрчлөлтийг хиймээр байгаа юм. Ер нь хүүхэдтэй холбоотой яг энэ засан хүмүүжүүлэх газрыг бид нар яг ингээд л гаднын хүний эрхийн байгууллагууд үзэхээрээ гайхдаг юм шүү дээ. Энэ чинь яагаад хүүхдээ бид нар ингэж хорьдог юм гээд. Энэ чинь өөрөө сургалтын байгууллага байх ёстой, хүмүүжлийн байгууллага байх ёстой байтал яг л хорих байгууллагын стандарт яваад байдаг тээ? Энэ дээр ер нь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Яах уу тодруулах уу? Баасанжаргал гишүүнд микрофон өгье.

Х.Баасанжаргал: Яамны зүгээс бас барьж байгаа бодлого нь юу байгаа юм бол? Шүүх яг энэ дээр ял оногдуулахдаа аль болох хорихгүй байх гэдэг тэр зүйлийг бас анхаарах хэрэгтэй байх гэж бодож байна. Ийм саналтай байгаа учраас зориуд бас энэ асуултыг асууж байгаа шүү гэж бодож байгаа.

Хамгийн сүүлд нь хуулийн төслийг үндсэндээ бүхэлдээ дэмжиж байгаа. Төсөв, санхүүгийн хувьд ялангуяа бид нар сая Хүүхэд хамгааллын хууль дээр анх удаагаа сум болгон, нэгж болгон дээр хүүхэд хамгааллын мэргэжлийн хүн авсан. Тэнд зөндөө олон алдаа оноо гаргаад явж байгаа. Тэр алдааг бас дахиад шүүх дээрээ бид нар алдмааргүй байгаа. Энэ шүүх ямар байх ёстой юм бэ гэдэг олон улс орны загварууд байгаа. Та бүхэн ч гэсэн олон улсын хурал хийсэн. Яг тэр загвар руу хэр дөхөх вэ? Тэн дээр бас манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд бас санаачилгатай байгаад Бямбацогт сайд энд сууж байна шүүхийн төсвийг дараа жил битгий танаж, тастаж бууруулж орж ирээрэй гэж бүүр зориуд өгсөн юм.

Д.Цогтбаатар: Эхлээд Бямбацогт сайдаас. Яг үнэн би ч асуумаар асуултыг асуучихлаа. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Шүүхийн төсөвтэй холбоотой асуудал Баасанжаргал гишүүн бас хөндөж байна. Тэгэхээр бид нар Шүүхийн тухай хууль, шүүхийн багц хууль

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

баталсан. 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шүүхийг бие даасан, шүүгч нар хараат бус байх заалт оруулсан. Үүнтэй холбогдуулж Шүүхийн багц хууль батлаад энэ үедээ шүүхийн төсвийг бас шүүхийг хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулахын тулд Засгийн газраар дамжуулж төсвийг нь Их Хуралд өргөн барьдаг энэ процессыг өөрчилсөн.

Яагаад гэвэл Засгийн газраар дамжаад Сангийн ямаар дамжихаараа шүүхээс, Засгийн газраас, гүйцэтгэх засаглалаасаа шүүх маань бас хараат болчих тийм эрсдэлтэй гэж үзсэн учраас шууд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд шүүхийн төсвийг өргөн барьдаг, шүүх, Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд баталдаг ийм хуультай болсон. Тэн дээр Хууль зүйн байнгын хороо үндсэндээ шүүхийн зардал, төсвийг энэнийх нь дагуу хэрэгжүүлээд төсвийн хэлэлцүүлгийн үед нэгтгээд явах энэ хуулиар л уул нь л явж байх ёстой ийм хууль хэвээрээ байгаа биз дээ? Хэвээрээ байгаа. Тэгэхээр энэ хууль хэвээрээ байгаа болохоор яг энэ хүрээндээ явах ёстой.

Тэгэхээр Засгийн газар гүйцэтгэх засаглалаасаа дутуу эрх мэдэлтэй хууль тогтоох байгууллага байх ёсгүй. Шүүхийн хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах энэ эрхэд гүйцэтгэх засаглал бас халдах ёсгүй. Би бас Хууль зүйн байнгын хорооны дарга байх үедээ бас яг энэ зарчим барьдаг байсан. Тийм болохоор энэ хуулийнхаа л хэрэгжүүлэх ёстой. Хуулийнхаа хэрэгжилтийг бид хангах ёстой. Хуулийн хэрэгжилтийг биелүүлэхийг Засгийн газраас, Сангийн яамнаас манай Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо шаардах, шахах эрхтэй, үүрэгтэй. Ингээд шүүх бол бие даасан хараат бусаар төсвөө Хууль зүйн байнгын хороо дамжуулж явах энэ хууль хэрэгжих ёстой. Энд Засгийн газар оролцохгүй гэдгийг бас хэлье.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 1 номерын микрофон Алтанчимэг шүүгч хариулах уу?

Г.Алтанчимэг: Баасанжаргал гишүүний асуусан тэр Дээд шүүх яагаад журам баталдаг юм бэ. Энэ өөр байгууллагууд ер нь журам баталбал яасан юм бэ гэдэг ийм холбогдолтой асуултад хариулъя. Энэ нөхцөл байдлын шинжээч гээд шинжилгээ гаргах ийм зохицуулалт шинээр энэ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын хуульд байгаа. Тэгэхлээр энэ нөхцөл байдлын шинжээч мэргэжилтэн гэдэг хүн чинь юу хийх юм бэ гэхлээр тухайн хэрэг маргааныг шийдэх гэж байгаа шүүгчид туслах зорилготой. Энэ юунд туслах зорилготой юм бэ гэхлээр тухайн маргалдаж байгаа гэр бүл ер нь анхнаасаа энэ гэр бүл хэдий хэмжээнд амьдарсан юм, ер нь энэ гэр бүлийн нөхцөл байдал ямархуу байсан юм анхнаасаа, одоо юу болчихсон юм бэ гэдэг энэ гэр бүлийн нөхцөл байдлыг суурь эхнээс нь шинжлээд, судлаад, тэгээд шинжээчийн дүг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон гүйцээгээд хариулъя.

Г.Алтанчимэг: Тэгэхээр энэ яг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу яг маргааны зүйл нь юм бэ, гэр бүл цуцлахтай холбоотой маш олон маргаанууд гардаг. Хүүхдийн асрамж, тэтгэлэг, эд хөрөнгийн маргаан гээд энэ маргаан болгон дээр нь нөхцөл байдлыг нь судална гэсэн үг. Тэгэхлээр энэ цэвэр өөрөө маргаантай холбоотой байгаа учраас шүүх өөрөө ерөнхийдөө гэр бүлийн хэрэг дээр ийм маргаан гарвал ямар нөхцөл байдлыг судлах ёстой юм бэ гэдэг тэр журмаа тогтооно гэдэг энэ үндэслэлээр энэ хуулийн 23 дээр ч бас нэлээн

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тодорхой заачихсан байгаа. Яагаад энийг Дээд шүүх хийх гэж байгаа шалтгаан нь. Тэгэхээр энэ үндэслэлээр Дээд шүүх тэр нөхцөл байдлын шинжээчийн үнэлгээг гаргах журмыг батална гэсэн ийм зохицуулалт орж өгсөн байна.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа.

Би нэг зүйл асуучихъя. Алтанчимэг шүүгч, Батсүрэн шүүгч хоёроос л асуух уу даа. Энэ ингээд яаж байна шүү дээ гэр бүл, хүүхдийн шүүх ингээд мэргэшсэн шүүх байна гээд. Гэтэл энэ дотроо эрүүгийн хэрэг, иргэний асуудлаа хоёулангаар нь гэр бүлийн асуудлаар л мэргэшсэн бол хоёулангаар нь мэргэшсэн байх гээд байна уу энэ чинь? Дотроо энийгээ ялгаж өгөхгүй бол одоо энэ процессын хууль ч гэсэн орж ирэхдээ яг холбогдох эрүүгийн процессын хууль эд нар шинэчлэгдээд орж ирж байна шүү дээ. Тэгэхлээр энийг чинь яаж, одоо би энэ юуг ингээд харж байхад анхан шат дээрээ ч, давж заалдах дээрээ ч гэсэн нэг л шүүх байгаад байх юм. Дотроо ер нь хоёр танхимтай байх юм уу яах юм? Би энийг гүйцэд бас ойлгож өгөхгүй яваад байгаа шүү.

Хэн хариулах бэ? 2 дугаар микрофон хариулах уу? Батсүрэн шүүгч 3 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Гэр бүлийн шүүхийн хянан шийдвэрлэх хэргийн харьяалалд хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг мөн хамааруулж үзэж байгаа. Тэгэхлээр энэ шүүхэд ажиллах шүүгч нь иргэний болон эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байх шаардлагатай. Шүүхийн ерөнхий зөвлөл сонгон шалгаруулалтыг явуулахдаа аль аль эрх зүйгээр, чиглэлээр шалгалтыг авч байгаа.

Улсын дээд шүүх энэ дагнасан шүүхэд танхим байгуулах асуудлыг тухайн шүүхийн болон Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн шийдвэрлэх эрхтэй. Ингэхдээ бас бүрэлдэхүүнийг батлах ийм эрхтэй байх саналыг өгч байгаа юм.

Тэгэхлээр гэр бүлийн шүүх дотроо гэр бүлийн иргэний чиглэлээр, мөн хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх эрүүгийн ийм 2 танхимтай байх боломжтой. Шүүх танхимыг, мөн бүрэлдэхүүнийг баталсан тохиолдолд тус тусын чиглэлээр мэргэшин ажиллах ийм боломж бол.

Д.Цогтбаатар: Энийг ер нь дотроо зохицуулчих боломж байна гэж би ойлгож байна тийм үү?

Тэгвэл ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Алга байна.

Тэгвэл хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье..

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ. Тийм манайхаас саналаа хариуцлагатай өгөөрэй.

2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт манайхан.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

6.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Манайхан саналаа өгөөрэй.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

7.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

8.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ горимын санал тэгвэл та гаргах уу? Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би үнэнээ хэлье. Би энийгээ дарж амжсангүй. Болдоггүй юм уу? Би харин дэмжих гэхээр тэр нь дарж амжсангүй шүү дээ. Хэн нь ажилласангүй, миний хуруу ажилласангүй юу. Ер нь ажилласангүй. Ямар ч байсан ажилласангүй. Тэгье, тэгээд хүчингүй болгоод өгөх үү?

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүний уншсан энэ чинь тэгвэл ингээд Эвлэрүүлэн зуучлалын хуулийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, Их Хурлаар, чуулганаар хэлэлцүүлъя гэсэн томьёоллыг түрүүн уншиж танилцуулсан. Тэр томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор. Санал хураалт. 53.3 хувиар санал дэмжигдлээ.

9.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

10.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

11.Шүүх байгуулах тухай хуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

12.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ. сүүлийнх

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

13.“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Энэтэй холбогдуулаад нээрээ би нэг юм хийхгүй бол түрүүн яачихжээ ажлын хэсгийг түрүүнийхтэйгээ адилхан гээд бас товчилж болохгүй юм байна. Энэ чинь архивд үлдэх учраас энд оролцсон ажлын хэсгийг би бүрэн гүйцэд уншаад танилцуулчихъя.

Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Г.Алтанчимэг Улсын дээд шүүхийн Иргэний танхимын тэргүүн, Б.Батцэрэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Г.Ганбаатар Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгч, П.Золзаяа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Г.Даваадорж Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, О.Амарсанаа Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль хууль зүйн доктор, дэд профессор, О.Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Я.Жавхлан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг сая оролцлоо хуралдаанд.

Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх хууль Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар гишүүн. Алтангэрэл гишүүн.

Ажлын хэсэгтээ баярлалаа. Бямбацогт сайдад баярлалаа. Тэгэхдээ Бямбацогт сайд аа, Бямбацогт сайд аа та нээрээ амлалаа шүү Сангийн сайдад яг энэ бол хууль, бид нар хууль шаардаад байгаа байхгүй юу. Түүнээс үзэмжийн юм ерөөсөө шаардаагүй.

14.09 цаг

Гурав дахь асуудалдаа орьё.

Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Байнгын хорооны тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Номинчимэг Номинчимэг гишүүн өөрөө хаана байна? Би өөрөө уншаад танилцуулчихъя тэгвэл. Тэгье.

Эрхэм гишүүд ээ,

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.1.1 дэх заалтын дагуу Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч бус гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 120-оос доошгүй хоногийн өмнө Байнгын хороонд болон олон нийтэд энэ тухай мэдэгдэх гэсний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 2021 оны 95 дугаар тогтоолоор томилогдсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн Н.Баасанжав, Н.Мөнгөнцэцэг, Р.Онончимэг, 96 дугаар тогтоолоор томилогдсон Д.Зүмбэрэллхам нарын бүрэн эрхийн хугацааны талаар Хууль зүйн байнгын хороонд мэдэгдсэн.

Дээрх гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Хууль зүйн байнгын хорооноос Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Байнгын хороо болон ажлын хэсгээс холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх, нэр дэвших тухай хүсэлт, материалд хүлээн авах ажлын хэсэг байгуулах, нэр дэвшигчдээ бүртгэж нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн баримт бичгийг parliament.mn цахим хуудаст байршуулах, нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх, ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах, нэр дэвшигчийг тодруулан Улсын Их Хуралд санал болгох гэсэн 8 үе шатын хүрээнд сонгон шалгаруулалтыг явуулсан талаарх танилцуулгыг та бүхэнд хүргэж байна.

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 3.1.1-д цаашид сонгон шалгаруулалтын журам гэнэ. Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд бүртгэхээ дээр тогтоож, сонгон шалгаруулалтын зарыг parliament.mn цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн сайтуудаар түгээсэн.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргах ажлын хүрээнд Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож, хүсэлт материалыг 21 хоногийн хугацаанд хүлээн авахаар нийтэд мэдээлсэн бөгөөд тус хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нийт 25 хүн нэрээ дэвшүүлэн холбогдох материалыг нэр дэвших хүсэлтийн хамт Хууль зүйн байнгын хороонд ирүүлсэн.

3.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.2-т ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, Хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон. Улсын Их Хурлын гишүүн ахална гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 15, 21-ний өдрүүдийн 14, 15 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ахалж, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны Хуулийн бодлогын хэлтсийн ахлах зөвлөх

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Г.Оргилболд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Х.Номингэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов, Ерөнхийлөгчийн намын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн эрдэмтэн, Нарийн бичгийн дарга Б.Дөлгөөн, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч П.Данзанноров, Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Амарсанаа, Шихихутаг их сургуулийн судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн, Нарийн бичгийн дарга Б.Нармандах нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

4.Нэр дэвшигчээр бүртгэх, нийтэд мэдээлэх ажлын хүрээнд ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж, хууль тогтоомжид заасан материалын шаардлагыг хангасан гэж үзэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлт, материалаа ирүүлсэн 25 хүнийг нэр дэвшигчээр бүртгэсэн тухай ажлын хэсгийн тогтоолыг баталж, сонгон шалгаруулалтын журмын 8.1-д нэр дэвшигчээр бүртгэснээс хойш ажлын 1 өдрийн дотор бүртгэсэн нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж түгээнэ гэж заасны дагуу 25 нэр дэвшигчийн материалыг parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан.

5.Нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын журмын 10.1-д сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэсэн шийдвэр гармагц ажлын хэсэг нэр дэвшигчийг ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж, илтгэгч гишүүнийг томилно гэж заасныг баримтлан 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр ажлын хэсгийн хуралдаанаар нэр дэвшигч тус бүрийн илтгэгч гишүүнийг сугалаагаар тодруулж илтгэгч гишүүнийг томилсон.

Илтгэгч гишүүн нь нэр дэвшигчдийн талаар ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг судалж, үнэн, зөвийг нягтлан хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээллийг судалж дүгнэх, сонирхсон этгээдээс ирүүлсэн асуулт, саналыг судлах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баримт, мэдээлэл гаргуулан авч, нэр дэвшигчтэй ярилцлага хийх, түүнээс нэмэлт мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах зэрэг ажиллагааг хийсэн болно.

Энэ хугацаанд нэр дэвшигчтэй холбоотой иргэд, олон нийтээс ирүүлсэн санал, мэдээллийг тухай бүрд илтгэгч гишүүнд хүргүүлсэн бөгөөд шаардлагатай мэдээллийг нягтлах зорилгоор эрх бүхий байгууллагаас тодруулга авч ажилласан болно.

6.Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах ажлын хүрээнд сонгон шалгаруулалтын журмын 11.1-д нэр дэвшигч нь холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилгоор ажлын хэсэг нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна гэж, 11.2-т ажлын хэсэг 6-аас доошгүй тооны гишүүний ирцтэйгээр ярилцлага хийх бөгөөд ажлын хэсгийн ахлагч даргална гэж заасны дагуу ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр ажлын хэсгийн ярилцлагыг зохион байгуулсан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 25 хүн нэр дэвшсэнээс 1 хүн нэрээ татаж, нийт 24 нэр дэвшигчтэй ярилцлага зохион байгуулсан.

7.Нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгох ажлын хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлд ажлын хэсгийн гишүүд илтгэгч гишүүний тайлан болон холбогдох бусад баримт мэдээлэлд үндэслэн нууцаар санал хураалт явуулж, санал хураалтын дүнгээр ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан 2 хүртэл хүний хамт нэр дэвшүүлж Байнгын хороонд тайлангийн хамт ажлын 3 өдрийн дотор хүргүүлэх гэж заасны дагуу ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хуралдаж илтгэгч гишүүд нэр дэвшигчдийн талаарх бэлтгэсэн дэлгэрэнгүй тайлангаа танилцуулж, нууц санал хураалт явуулсан.

Нууц санал хураалтад ажлын хэсгийн 11 гишүүнээс 10 гишүүн оролцож, сонгон шалгаруулалтын журамд заасны дагуу нэр дэвшигч тус бүрээр саналаа өгсөн бөгөөд 24 нэр дэвшигчээс Х.Эрдэм-Ундрах, Ч.Баянжаргал, Ц.Жавхлантөгс, Ч.Өнөржаргал нар ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авч, сул орон тоонд дэвшүүлэх тоо бүрдсэн тул ажлын хэсэг дээрх нэр дэвшигчдийг Хууль зүйн байнгын хороонд санал болгохоор тогтож, ажлын хэсгийн тогтоолыг баталсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчид

1.Х.Эрдэм-Ундрах 8 санал, Ч.Баянжаргал 7 санал, Ц.Жавхлантөгс 6 санал, Ч.Өнөржаргал 6 санал. Сонгон шалгаруулалтын журмын 13.2-т Байнгын хороо энэ журамд заасны дагуу хүсэлт, тайланг байршуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор томилгооны сонсголын товыг тогтож, нийтэд мэдээлнэ гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар нэр дэвшигч нартай хийх “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэсэн болно.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Номинчимэг гэсэн байна. Ажлын хэсгийн дарга.

Ингээд танилцуулгыг хийлээ. Тогтоолын төслийг та бүгдэд тараасан байгаа.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Тийм. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Нэгдүгээрт, эхлээд надад горимын санал байна. Өнөөдөр энийг боливол яасан юм тийм ээ? Одоо бид нарын хамгийн чухал асуудал хамгийн сүүлд нь тавигдаад 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 гишүүн. Би яагаад энэ их чухал асуудал гэж бодож байна вэ гэхлээр энэ нэгдүгээрт Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний асуудал.

Хоёрдугаарт, энэ чинь сая болоод өнгөрчихсөн гэж ярьж байгаа байхгүй юу. Тэгээд юу болоод өнгөрснийг бас сайн ойлгоогүй.

Гуравдугаарт, энэ талаар хүмүүс зөндөө гомдол надад гаргасан.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дөрөвдүгээрт, манай Их Хурлын гишүүдийн эрхэнд халдчихаад байна шүү дээ хөөе. Бид нар чинь Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг бид нар Их Хурал гаргах ёстой байхгүй юу. Тэр дотроо манай Байнгын хороо их серьёзны ярих ёстой юм. Гэтэл хуучин бид нар юун дээр хэрэлдэж байсан юм гэхээр 24 хүн нэр дэвшсэн гэж байгаа юм. 24-өөс ядаж 4-н орон тоон дээр 4-өө гаргаад запаас 2-ыгоо өгөөрэй гэсэн чинь наадуул чинь мухарлаад 4 болгоод оруулаад ирж байна шүү дээ. Бид нарын эрхэнд яагаад халдаад байгаа юм? Үгүй тэгээд 24 хүнээс 4-хөн хүнийг гаргаж ирчхээд одоо чи энэ сонсгол явуулаад гарга гэхэд тэр 4 л гардаг юм байгаа биз дээ? Их Хурал дээр орохоороо дахиад тэр 4-ийг муу ч, сайн ч гаргадаг юм. Ингэж тогломооргүй байна. Ингэж шударга бус хандмааргүй байна. Тэгээд энэ их чухал асуудал учраас эрхэм гишүүд намайг дэмжээд өгөөч. Намирах нь байвал дэмж л дээ. Тэгээд хойшлуулчихъя. Жаахан тухтай ярь л даа. Ингэж болохгүй. Ер нь энэнээс энэ нэг асуудал биш энэнээс болоод иргэд магадгүй энэ арай жоохон хүрээгээрээ хуульчдын дунд бид нарын нэр хүнд шууд унаж байна шүү дээ. Бид нарын гэдэг нь хуулийн манай Байнгын хороо, манай Их Хурлын нэр хүнд эд нар новшроод ингээд хэдэн таньдаг амьтадтай лоббидоод тэр сургуулийн тэрийг гаргана, энэнээс энийг гаргана гээд. Тэгээд хуулийн хувьд мэргэшчихсэн амьтдыг хуулийн ямар ч мэргэшээгүй амьтад нь шүүж гаргадаг гээд ингээд бүүр тоглоом тохуу боллоо. Хэдүүлээ зөв шийдчих арга байна уу? Эрхэм гишүүд ээ дэмжээрэй.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би энэ дээр энэ өөрөө өөрийгөө нэр дэвшүүлдэг, сонгон шалгаруулалтын концепцыг бас яг бодож хууль боловсруулдаг ажил хийж байхдаа оруулж ирсэн хүн юм байгаа юм. Хүний эрхийн Үндэсний Комиссоос яг энэ жишгийг оруулж ирсэн. Дараа нь ингээд Шүүхийн хууль дээр оруулж ирсэн боловч сая Алтанхуяг даргын хэлж байгаа шиг ийм гаж юмнууд гарчхаад байна. Шууд тулгадаг. Шууд 11 хүнийг байгуулахаасаа эхлээд будилаантай болсон. Шүүхийн төлөөлөл орсон. Энэнээсээ орж ирэнгүүтээ яг ийм сонголтгүйгээр ийм хязгаарлагдмал хүрээнд явж ирсэн. Энийг яг өмнөх Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг томилоход бас яг яриад энийг дараагийн удаад хийхгүй илүү сонголттой орж ирнэ гэдэг зүйлийг ярьсан. Яг л хэвээрээ. Яагаад энэ буруу жишгүүдийг ингэж орж ирээд байгаа юм? Энэ 4 хүнийг би мэдэж байна. Бараг эзнийг нь ч хэлж чадна. Ард нь хэн хэн түлхэж байгааг. Шулуухан хэлэхэд нэр устай нь хэлж чадна. Энэ 4 хүнийг заавал томилох албагүй.

Тийм учраас бид хэдэд яг үндсэндээ 24 хүний материал гар дээр эхлээд ирэх ёстой. Ийм юмнаас авсан, ярилцлагад хэдэн оноо авсан. Тэгээд эцсийн дүндээ энэ дээрээс бас тодорхой хэмжээний нөөцтэй гэдэг юм уу орж ирээд ингээд сонгохгүй бол одоо энэ 4-ийг сонгохгүй та нар Шүүхийн ерөнхий зөвлөл бараг ажиллах бололцоогүй болох гэж байна гээд сүржигнэнэ. Би энийг мэдэж байна. Тэгэхдээ Монгол Улсын шүүхийн тухай хуулийг бас анхлан санаачилж, бичиж, боловсруулж, батлуулж байхдаа арай ч ийм юм бодож хийгээгүй шүү. Ийм хуйвалдааны онол дээр явна гэж юм хийгээгүй шүү. Энэ тэгээд өнөөдөр даргын халааснаас гарч ирдэг нэрийг уг нь өөрөө өөрийгөө дэвшүүлдэг мэргэжлийн хүмүүс орж ирэг гэсэн чинь одоо энэ дээр ажлын хэсэг ингээд 4-хөн хүнийг ингэж цавчиж орж ирээд бусдуудыг нь бид нарт хаалттай үлдээчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм байдлаар явж болохгүй. Хууль зүйн байнгын хороо зарчим ярих ёстой. Би энэ ажлын хэсгийг байгуулахаасаа эхлээд, бүрэлдэхүүнээсээ эхлээд буруу явлаа шүү, хазайлаа шүү гэдэг зүйлийг хэлсэн. Яг ингээд явж байгаа.

Тэгээд энэ 24 хүн дотор ч хүртэл ярьж болох байхгүй юу. Яагаад би хэлэх гээд байна гэхээр Улсын дээд шүүхийн Тамгын дарга хүртэл өрсөлдөж байгаа юм. Дээд шүүхийн Тамгын дарга шүүгч бус гишүүнд өрсөлдөж болохгүй байхгүй юу. Наад захын ингээд би тэр хүнд ч гэсэн орж ирэхээр нь хэлье гэж бодсон юм. Тэгээд энэ чинь өөрөө эргээд 10 хүний 5 шүүгч нар, 5 шүүгч бус буюу шүүгч бус гэхээр захиргаан дээр ажиллаж байгаа хүмүүс гэж өөрийгөө бас бодоод байх шиг байгаа юм. Энэ нь өөрөө эргээд огтоосоо шүүх эрх мэдэлд ажилладаггүй буюу ийм хүмүүс байх ёстой ерөнхийдөө ерөнхийдөө. Ингээд явахгүй бол наад чинь ингээд одоо асуудлууд байгаа.

Тэгээд одоо ингээд ийм үл бүтэх байдлаар энэ 4 хүнийг зүгээр л би ард нь хэн хэн түлхэж байгаа, ямар хуваарилалтууд явчхав гэдгийг ч хэлж чадна. Тэгэхээр энийгээ нээлттэй явуулах ёстой. Энийгээ харин ажлын хэсэг дахиж ярилцаад заавал дахиад запаас 2 гэж байгаа юм биш. Хэд ч байсан хамаагүй 8, ерөнхийдөө бас оруулж ирж энэ чинь хэлэлцүүлээд ингэж явах ёстой шүү. Тэгээд ийм ямар журмаар орж ирж байгаа 4 гэх нь мэдэхгүй. Ийм байдлаар орж ирж болохгүй гэдэг зүйлийг хэлье. Ингэх юм бол энэ Шүүхийн тухай хууль.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Байз энэ бас харамсалтай зүйл байх юм. Энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн байх, Шүүхийн ерөнхий зөвлөл чинь өөрөө Үндсэн хуулийн институт. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн гэдэг чинь шүүгчдийг сонгон шалгаруулдаг, шүүхийн хараат бус байдлыг хангадаг энэ их чухал байгууллага шүү дээ Шүүхийн ерөнхий зөвлөл. Тэгээд гишүүн гэдэг чинь их хариуцлагатай ажил. Тэгээд энийг сонгон шалгаруулах ажил гээд тэгсэн баахан хүн бужигнуулаад шалгаруулаад байна гэсэн өнөөдөр ингээд танилцуулах гэхээр ямар шалгуураар, хэн шалгасан юм, ямар процесс явсан юм гээд тайлбар өгөх хүн байхгүй. Ач холбогдол өгч байгаа хүн байхгүй. Үгүй ингэххээд бид нар дараа нь шүүхээсээ яаж сайн сайхан юм нэхэх юм бэ, яаж энэ шүүх чинь шударга бус байна, яаж болохгүй байна гэж бид нар дараа нь ярих юм. Энэ чинь логикийн хувьд ерөөсөө болохгүй байна шүү дээ.

Тэгээд Улсын Их Хурал өөрөө томилдог байгууллага болохоос биш тэр ажлын хэсэг, бүрэлдэхүүнд орсон хэдэн хүмүүс Улсын Их Хурлын өмнөөс нэг ёсны ямар ч сонголт, алтернатив байхгүй шийдвэр гаргачихсан байна шүү дээ. Энэ хэдийг сонгоод ир гээд. Үгүй дунд нь сайн хүмүүс байна. Үнэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн хийгээд миний хувьд дэмжих хүн байна. Тэгэхдээ тэр 24 хүнээс 25 байж байгаад 1 нь нэрээ татсан гэж байна шүү дээ. 24 хүнээс нөөц 2 хүний санал оруулаад ирэхгүй хэн ч олонхын санал аваагүй гэж тайлбарлаж байна гэдэг чинь ер нь хүчээр та нар энэ хүмүүсийг сонго гэж бид нарт тулгаж байна шүү дээ. Энэ чинь социализмын үеийн хүний нэр дугуйлдаг сонгуулиас ямар ялгаа байдаг юм? Та нар энэ хүмүүс дээр л ярилц гээд. Тэгэхээр бид 2 зүйлийг анхаарах ёстой юм байна.

Нэгдүгээрт, энэ сонсголыг томилж явуулах хүн дээрээ бас нэлээн туршлагатай хүн баймаар байна. Би энэ шүүхийн талаар олон жил дуугарсан, олон сонгогдсон, нэлээн туршлагатай бас энэ шүүх дээр санаа зовж, хуульд нь

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

өөрчлөлт оруулах гэж ярьж явдгийн хувьд Алтанхуяг гишүүнийг бас энэ сонсголыг ахлаад яваасай гэж бодож байна. Нэг.

Хоёр дахь асуудал нь ерөөсөө бидэнд сонголтгүйгээр энэ хүмүүсийг сонго гэж тулгадаг, эд нар дээр л та нар ер нь саналаа өг гэдэг тулгадаг байдал дээр Хууль зүйн байнгын хорооны гишүүд ер нь өөрсдөө бид нар өөрсдөө саналаа бие дааж гаргах ёстой Улсын Их Хурлын тухай хууль болон бусад хуулиудаараа бид нарт энэ бүх эрх хэмжээ нь байгаа гэдгээ санаж цаашдаа энэ асуудалд хандъя. Өнөөдрийн хувьд бас ингээд хойшлуулчих нь зөв байх гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Би энэ дээр саяын гишүүдийн хэлж байгаа бүх саналтай харин санал нэг байна. Ер нь ингээд тулгаж оруулж ирээд тэгээд Хууль зүйн байнгын хороо хэлбэр төдий алх цохидог кнопчид биш. Тийм ч байх ёсгүй. Энэ бол маш ул суурьтай хандах ёстой асуудал. Хэлэлцүүлье гэхэд ажлын хэсгийн дарга маань ч байхгүй байна.

Тийм учраас энийг хойшлуулахыг дэмжье гэсэн томьёоллоор энэ Алтанхуяг гишүүний гаргаж байгаа горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Манайхан бэлдээрэй. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ. Хурал хойшлогдлоо.

Өнөөдрийн хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул хуралдаан дууслаа.

Гишүүддээ ирж оролцсонд талархал илэрхийлье.

14.30 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР